



**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ АГЕНТЛАГ БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТ**

2023.12.05

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны
100 дугаар тушаалын 7 дугаар хавсралт

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ АГЕНТЛАГ БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хувь
НЭГ. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД							
Зорилт 1.1 Уялдаа: АЗДҮАМХ 3.1		Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллана.					
1.1.1	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллах;	-	Чанар, үр дүн, хэрэгжилтийн хувь, хугацаандаа тайлагнасан байдал;	2022 оны хяналт, шинжилгээ, үнэлгээний дүн	Салбарт хамаарал бүхий зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж, холбогдох газруудад тайлагнасан байна.	-Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын бодлогын баримт бичиг, холбогдох эрх зүйн акт, хууль тогтоомжийн биелэлтийг аймгийн Засаг даргын 2021 оны А/342 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу биелэлтийг гаргаж, үр дүнг тооцож тогтоосон хугацаанд холбогдох газруудад тухай бүр хүргүүлсэн. Аймгийн ЗДТГ-аас 2022 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдэж, 89,0 хувьтай дүгнэгдсэн.	100
1.1.2	Байгаль орчны хууль тогтоомжийг сурталчлах, байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах талаарх иргэд олон	-	Мэдээлэл, сургалт сурталчилгааны тоогоор	-14 удаагийн сургалт, уулзалт, зөвөлгөөн зохион байгуулж 1300 орчим иргэд хамрагдсан.	Байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх зохистой ашиглах талаарх иргэд олон нийтийн мэдлэг, хандлагыг	Байгальд ээлтэй хандлага, зөв дадал, шийдлүүдийг танилцуулах, ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар орон нутагт тулгамдсан асуудал, зорилтыг хангах зорилгоор иргэд олон нийт, өсвөр	100

	<p>нийтийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах;</p>			<p>дээшлүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулж, эх бэлтгэл, постер, цахим орчинд хийсэн контент, нэвтрүүлэг, мэдээ сурвалжлага хийлгэсэн байна.</p>	<p>үеийнхэнд зориулж 19 суманд 35 удаагийн сургалт, 7 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж 5100 иргэн хамрагдаж, Хужирт суманд “Эко анги” тохижуулж, өсвөрийн байгаль хамгаалагчдыг бэлтгэх зорилгоор 20 удаагийн сургалт, “Эко клубүүдийн чуулга уулзалт, 2 удаагийн “Эко аялал” “Илтгэлийн уралдаан”, “Эссе бичлэг” зэрэг арга хэмжээг зохион байгуулж 3200 гаруй хүүхэд хамрагдсан.</p> <p>“Бид эх дэлхийн хүүхдүүд” эко клубүүдийн чуулга уулзалтыг 04 сарын 17-18-ны өдрүүдэд Арвайхээр хотод зохион байгуулж, ерөнхий боловсролын 30 сургуулийн эко клуб оролцож, байгаль орчныг хамгаалах, экологийн боловсрол олгох, туршлага, мэдээлэл солилцох, мэтгэлцээн, хэлэлцүүлэг зохион байгуулж, шилдэг илтгэгч, шилдэг Эко клубүүдийг шалгаруулан Өвөрхангай аймаг дахь Политехникийн коллеж, Мэргэд лаборатори сургууль, Уянга сумын 2-р сургууль, Бат-Өлзий сумын ерөнхий боловсролын сургуулиуд шилдэг эко клубээр шалгарлаа.</p> <p>-Ан амьтан хамгаалах, экологи эдийн засгийн үнэлгээ, ус хэмнэх энгийн арга, жимсний болон гоёл чимэглэлийн мод сөөг тарьж ургуулах чиглэлээр 17 төрлийн 4000 гаруй зөвлөмжийг бэлтгэж иргэд олон нийтэд тараасан.</p> <p>-Сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нарын нэгдсэн сургалт, зөвлөгөөнийг 3 дугаар сард зохион байгуулж холбогдох албан хаагчдыг бүрэн хамруулсан.</p> <p>-2023 онд орон нутгийн “Хас телевиз”, “Соёмбо”-тэй гэрээ байгуулж 19 удаагийн мэдээ, 3 нэвтрүүлэг, сэдвийн</p>
--	--	--	--	---	--

						сурвалжлага 3, хоёр шторк хийлгэж, МҮОНТ-ын Цагийн хүрд мэдээллийн хөтөлбөрт 11 мэдээ явуулж, “Оюунана брэнд” ХХК-тай гэрээ байгуулж 15 эх бэлтгэл, сурталчилгааны постер хийлгэж, байгууллагын албан ёсны цахим сайт nature.ov.gov.mn болон пэйж хуудсаар цаг үеийн мэдээллийг тухай бүр дамжуулан байгаль орчны хууль тогтоомж, мэдээ мэдээллийг иргэд олон нийтэд хүргэж ажилласан.	
1.1.3	“Иргэн бүр байгаль хамгаалагч” уриан дор байгаль орчныг хамгаалах, зөв дадал зуршил бий болгох зорилгоор сургалт, зөвлөгөөн, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах, шаардлагатай сумдад идэвхтэн байгаль хамгаалагч улирлын чанартай ажиллуулах;	5.0	-Идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах журмын хэрэгжилт хангагдсан байна. -Сургалт, зөвлөгөөн, нөлөөллийн ажлууд хийгдсэн байх	-	Шаардлагатай сумдад Идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулж, урамшуулсан байна.	“Байгальд ээлтэй хүүхэд, залуусын чуулга уулзалт”-ыг “Иргэн бүр байгаль хамгаалагч” уриан дор 2023 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Хархорин суманд зохион байгууллаа. Чуулганд Арвайхээр сумын ЕБ-ын “Мэргэд”, “Тэмүүлэл эрдэм”, 1, 2, 4 дүгээр сургууль, Хархорин, Өлзийт, Бат-Өлзий, Хужирт сумдын 9-12 дугаар ангийн 80 оролцогч, 8 чиглүүлэгч сурагч, зохион байгуулалтын баг, зочин илтгэгч нийт 113 хүн хамрагдаж Хэрэйд, Боржигон, Бэсүд, Олхунуд, Сартуул, Хатагин, Урианхай, Чинос зэрэг овог, аймгуудад хуваагдан “Хулгайн ан, худалдаа”, “Уул уурхай, хорт бодис”, “Бэлчээрийн талхагдал” зэрэг сэдвийн хүрээнд хэлэлцэж “Тогтоолын төсөл” батлан, “Тунхаг” бичиг боловсруулж шийдвэр гаргагчид өргөн барилаа. Уянга, Бат-Өлзий сумд аялал жуулчлалын улиралд идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулж, урамшуулсан..	100
1.1.4	Байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчлийг бууруулах зорилгоор хуулийн байгууллагуудтай хамтран урьдчилан	Онт 75,6	-Хяналт шалгалтын дүнд илрүүлсэн зөрчлийн тоо	Хүрээлэн буй орчныг хамгаалах журмын эсрэг 103 зөрчлийн мэдээлэл бүртгэгдэж, 74	Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хяналт шалгалтыг аймгийн	-Байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчлийг бууруулах зорилгоор аймгийн ГХУСАЗСЗ, Цагдаагийн газартай хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллалаа. Аймгийн хэмжээнд нийт 82 зөрчлийн гомдол	100

	сэргийлэх ажил, хяналт шалгалт зохион байгуулах;		-Урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ;	зөрчилд 42.1 сая төгрөгийн торгууль оногдуулж, байгальд учирсан хохирлын 53.3 сая төгрөгийг нөхөн төлүүлж, 4 зөрчлийн мэдээллийг хүлээн авахаас татгалзаж, 23 зөрчлийг харьяаллын дагуу бусад хуулийн байгууллагад шилжүүлсэн.	хэмжээнд зохион байгуулсан байна.	<p>мэдээллийг хүлээн авч шалган шийдвэрлэх ажиллагаа явуулснаас Амьтны тухай хууль зөрчсөн 32 иргэнд нийт 6,900,000 мянган төгрөгийн торгууль оногдуулж, байгаль орчинд учирсан хохирлын 64,87,000 мянган төгрөгийг нөхөн төлүүлж, цагаан зээр, тарваганы хууль зөрчсөн 23 иргэнд нийт 6,850,000 мянган төгрөгийн торгууль оногдуулж, ойд учирсан хохирлын 1,826,979 мянган төгрөгийг нөхөн төлүүлж, хууль бусаар бэлтгэсэн 149 ширхэг гуалин мод, 202.95 кг хуш модны самрыг хураан зохих журмын дагуу шийдвэрлэлээ. Зөрчлийн 4 мэдээллийг хүлээн авахаас татгалзаж, гэмт хэргийн шинжтэй 3 зөрчлийн харьяаллын дагуу шилжүүлж, 3 зөрчлийн шалган шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.</p> <p>-Нийт 77 зөрчилд 50,100,000 мянган төгрөгийн торгууль оногдуулж, байгальд учирсан хохирлын 114,324,000 төгрөгийг нөхөн төлүүлж шийдвэрлэлээ.</p> <p>-2023 онд хүрээлэн буй орныг хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилсан сэргийлэх ажилд 13,0 сая төгрөг төсөвлөж, урьдчилан сэргийлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж ажиллалаа. 2022 онд 103 зөрчил бүртгэгдэж байсан бол 2023 онд 82 зөрчил бүртгэгдэж өмнөх оноос 20 хувиар буурсан үзүүлттэй байна. Тарваганы мах, махан ороомог, зэрлэг гахай, чоно, үнэгний арьс, эвэр яс, тагтаа, ногтруу, шонхор гэх мэт нийт 356 ширхэг амьтны гаралтай мах түүхий эд, эд зүйлсийг хураан зохих журмын дагуу шийдвэрлэлээ.</p>
--	--	--	---	--	-----------------------------------	--

						Цаг үеийн шинж чанартай хамтарсан хяналт шалгалтуудыг 7 удаа зохион байгууллаа. Сум бүрийн байгалийн онцлого, цаг үеийн байдалд тохируулан сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч нарыг 2023 онд урьдчилан сэргийлэх эргүүл, хяналт шалгалт хийх дэлгэрэнгүй хуваарийг гарган баталж хүргүүлж хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилласан. Мөн байгаль орчны хууль тогтоомж, байгаль орчныг хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, экологийн болон хууль эрхзүйн боловсрол олгох, уламжлалт хэвшмэл буруу ойлголтын эсрэг 1 минутын 10 ширхэг видео шторк хийж цахим орчинд түгээн ажиллаж байна.	
1.1.5	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, ЗГ-ын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 02 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын хэрэгжилтийг хангах;	-	Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого-50 хувь Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого-85 хувь Ус рашаан ашигласны төлбөрийн орлого-55 хувь	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого 2022 онд ан амьтны нөөц ашигласны төлбөр-2,4 тэрбум, ойн нөөц ашигласны төлбөр-713,9 сая, ус рашаан ашигласны төлбөр-429,7 мянган төгрөг тус тус төвлөрсөн.	-Сумдын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлагналтад хяналт тавьж, бодлого чиглэлээр хангаж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байх -аймагт хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг ИТХ-аар хэлэлцүүлж батлуулан журмын дагуу зарцуулж, орлогыг төвлөрүүлэн мэдээ тайланг	Аймгийн ИТХ-ын “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 15/06 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтаар байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 147,866,90 мянган төгрөг батлагдсан. Уг зардлаар нийт 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр ЗГ-ын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 02 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу боловсруулж батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа. -2023 онд сумдад нийт 1,9 орчим тэрбум төгрөг хуваарилагдаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. -Аймгийн хэмжээнд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого 2023 оны 11 сарын байдлаар ан амьтны нөөц нөөц ашигласны төлбөрийн орлого 1,123,393,624 мянган төгрөг, ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	100

					хугацаанд нь тайлагнасан байна.	695,666,383 мянган төгрөг, ус, рашаан ашигласны төлбөрийн орлого 579,510,057 мянган төгрөг нийт 2,670,570,064 тус тус төвлөрөөд байна.	
1.1.6	Байгаль орчны статистик мэдээллийг https://www.eic.mn/boh/ программд тогтоосон хугацаанд бүртгэх ажлыг зохион байгуулах;	-	Уул уурхай, ой, ус, ан амьтны нөөц ашиглалт, хог хаягдлын тайланг 9 үзүүлэлтээр	Уул уурхай, ой, ус, ан амьтны нөөц ашиглалт, хог хаягдлын тайланг 19 сумаар гаргасан.	Тайланг 19 сумын тайланг хянаж нэгтгэн программд тогтоосон хугацаанд оруулсан байна.	Байгаль орчны статистик мэдээ болох “БОХ” тайланг шинэчилсэн маягтын дагуу ойн сангийн өөрчлөлт, нөхөн сэргээлт, ашигт малтмалын нөөцийн өөрчлөлт, ус ашиглалт, хамгаалалт, агнуурын нөөц ашиглалт хамгаалалт, хог хаягдлын чиглэлээр сумдаас гаргуулж, тогтоосон хугацаанд нэгтгэж байгаль орчны мэдээллийн сангийн программд http://www.eic.mn/box/login.php хаягаар 19 сумын 131 тайланг бүртгэх ажлыг хийж гүйцэтгэлээ.	100
1.1.7	Салбарын сайдаас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг хариуцан зохион байгуулах, тайлагнах.	-	Гэрээний хэрэгжилт, үр дүнгээр	2022 оны гэрээний үүргийн биелэлт 91,1 хувьтай хэрэгжсэн.	Гэрээнд тусгагдсан зорилт арга хэмжээний биелэлтийг хэрэгжүүлж, тогтоосон хугацаанд холбогдох газруудад тайлагнасан байх;	-Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон мэргэжилтнүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд заалт тус бүрээр тусгаж зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжилтийг тооцож ажиллалаа. Биелэлтийг хагас бүтэн жилээр гаргаж аймгийн Засаг даргын албан тоотойр БОАЖЯаманд хүргүүлсэн.	100
Зорилт-1.2		Хүний нөөцийн талаарх бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх					
1.2.1	Байгууллагын бүтэц, орон тоог оновчтой төлөвлөж, батлагдсан төсвийн хүрээнд ажиллах, хүний нөөцийн томилгоог холбогдох хууль журмын дагуу зохион байгуулах;	-	-Батлагдсан бүтэц, төсвийн хүрээнд ажилах -Хууль бус томилгоо хийгдээгүй байх	2022 онд батлагдсан төсвийн дагуу ажиллаж, хууль бус томилгоо хийгдээгүй.	-Бүтэц орон тоо, цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох -Сул орон тооны захиалгын салбар зөвлөлд уламжилж, нөхөх -Хүний нөөцийн томилгооны	-“Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” ЗГ-ын 2022 оны 417 дугаар тогтоолоор Мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдаж байгаль орчны хяналт тус газарт шилжсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн А/126 дугаар захирамжаар байгууллагын бүтэц орон тоонд нэмэлт өөрчлөлт оруулж батлуулсан.	100

					зөрчилгүй ажилласан байх	-Төрийн захиргааны албан хаагчдын ангилал зэрэглэл өөрчлөгдсөн тул газрын даргын 2023 оны А/01, Б/01 дүгээр тушаалаар албан тушаалын жагсаалт, цалингийн хэмжээг шинэчлэн баталж тухайн жилд батлагдсан төсөв, бүтцийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. -Төрийн жинхэнэ албаны сул орон тоог Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу шилжүүлэх, сэлгэн ажиллуулах зарыг ажлын 5 өдөр нийтэд ил тод зарлаж, орон тоо нөхөгдөөгүй тохиолдолд Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөр тусгай шалгалт зарлуулан Төрийн албаны хууль тогтоомжийн дагуу нөхөж байна. 2023 онд Бат-Өлзий, Хархорин, Есөнзүйл, Хайрхандулаан, Нарийнтээл сумдад 6 сул орон тоо гарч тусгай шалгалтыг 3 удаа зарлуулж, Хархорин, Есөнзүйл сумын байгаль хамгаалагчийн орон тоо нөхөөд байна.	
1.2.2	Байгууллагын дүрмийг шинэчлэх, зарим албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж батлуулах;	-	Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	2019 онд шинэчилсэн.	-Газрын дүрмийг шинэчилж АЗД-ын захирамжаар батлуулах -Шинэчлэх шаардлагатай албан тушаалын тодорхойлолтуудыг шинэчилж боловсруулан ТАЗ-өөс зөвшөөрөл авч батлуулсан байх	БОАЖЯамнаас үлгэрчилсэн дүрэм батлагдаж ирээгүй тул байгууллагын дүрмийг шинэчлэх ажил хийгдээгүй. Байгууллагын бүтэц өөрчлөгдсөнтэй холбогдуулан Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Ойн асуудал хариуцсан мэргэжилтэн, Байгаль хамгаалагчийн албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, Төрийн албаны зөвлөлөөс батлах зөвшөөрөл авахаар холбогдох материалыг бүрдүүлж Төрийн албаны зөвлөлд уламжлаад байна. Мөн Төрийн албаны зөвлөлөөс аймгуудын Байгаль орчин, аялал жуулчлалын	100

						газруудын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэхтэй холбогдуулан авсан төсөлтэй танилцаж санал хүргүүлсэн.	
1.2.2	Төрийн албан хаагчийн шагнал урамшууллыг ажлын гүйцэтгэл, үр дүнтэй уялдуулах олгох;	-	Ажлын гүйцэтгэл, шагналын болзол хангасан байдал	2022 онд төрийн болон салбарын шагналд 6 ажилтныг тодорхойлж, төрийн албан хаагчдын төсвийн шууд захирагчтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөг жилийн эцсээр үнэлж дүгнэн үр дүнгийн урамшуулал олгосон.	-Ажлын үр дүнг тооцох -Төрийн болон салбарын шагналд албан хаагчдыг тодорхойлох;	Төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг холбогдох журмын дагуу хагас бүтэн жилээр үнэлж дүгнэсэн.	100
1.2.3	Төрийн үйлчилгээний болон төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөн ажиллах.	-	Журмын хэрэгжилт хангагдсан эсэх	Сүүлийн 3 жилд ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй.	-Ёс зүйн тайлан мэдээг цаг тухайд нь холбогдох газарт хүргүүлсэн байх	-Тус газрын бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт орсонтой холбогдуулан байгууллагын Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/05 дугаар тушаалаар баталсан. 2022 онд шинэчлэн баталсан байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд төрийн албан хаагчийн ёс зүйн талаар тусгаж, төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний талаар холбогдох заалтуудыг тусгаж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. -Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Байгаль хамгаалагч нарын нэгдсэн сургалт зөвлөгөөнийг 2023 оны 4 сарын 03-ны өдөр Арвайхээр хотод	100

						зохион байгуулж, ахлах мэргэжилтэн Э.Золзаяа “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Авлигийн эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт” сэдвээр мэдээлэл бэлтгэж танилцуулсан. 2023 онд тус газрын албан хаагчдын ёс зүй харилцаа хандлагын талаар ямар нэг гомдол ирээгүй бөгөөд зөрчил гаргасан албан хаагч байхгүй.	
Зорилт 1.3 Уялдаа: АЗДҮАМХ 4.1.3.1-3.4		Ойн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, ойг нөхөн сэргээх, хамгаалах, зүй зохистой ашиглах талаар					
1.3.1	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах;	ОНТ 10.0	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2022-2030 оны хугацаанд “Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд аймагт тарих модны урьдчилсан тооцооллыг улсын стратеги төлөвлөгөөнд тусгуулахаар ЕТГазар, БОАЖЯаманд хүргүүлсэн.	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө болон аймгийн Ойн менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулсан байх.	“Тэрбум” мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 2022-2030 оны хугацаанд тарих модны тооцоолол, стратеги, төлөвлөгөөний урьдчилсан төслийг боловсруулж, БОАЖЯам, Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн. Улсын стратеги төлөвлөгөө батлагдсантай холбогдуулан аймгийн Ойн менежментийн төлөвлөгөөтэй хамтатган шинэчлэн боловсруулж аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж Ойн газраар батлуулахаар уламжилаад байна.	100
1.3.2	Мод, сөөгийн үрийн нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;	-	Аймгийн хэмжээнд шаардлагатай мод, сөөгийн үрийн нөөц бүрдүүлсэн байх;	2022 онд навчит модны үр 120 кг, шилмүүст модны үр 180 кг бэлтгэсэн.	-Шилмүүст модны үр- 100 кг-аас дошгүй, -Навчит модны үр- 200кг-аас доошгүйг бэлтгэсэн байна.	2023 онд аймагт мод үржүүлгийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагууд хайлаасны үр 150 кг, шар хуайс- 30 кг, гоёл чимэглэлийн модны үр 20 кг, хуш модны үр 100 кг, шинэсний үр 35 кг-г тус тус түүж бэлтгэсэн байна.	100
1.3.3	Мод үржүүлэг, ойжуулалт, ойн зурвас, суурин газрын цэцэрлэгжүүлэлтийн зориулалтаар ажил хийх хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгж, иргэдэд	-	Мод тарих газрыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд	2022 онд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2022-2030 хүртэл хугацаанд мод тарих боломжтой	2023 оны сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд мод тарих 358.7 га талбайг тусгаж, олгосон байна.	Газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөнд 11 суманд 35 га газрыг мод тарих, ногоон байгууламж байгуулах, 10 га талбайг мод үржүүлгийн газар байгуулах иргэн аж ахуйн нэгжид олгохоор тусгаж 60 орчим га талбайг ойн зурвас, ойжуулалт хийх зориулалтаар	100

	шаардлагатай газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авч, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган, холбогдох хууль, журмын дагуу шуурхай шийдвэрлэж ажиллах;		тусгаж олгосон эсэх;	газруудын байршил, судалгааг гаргаж, 100 га талбай олгосон.		олгож, 2022 онд 13 суманд 458,7 га газрыг мод тарих, ногоон байгууламж байгуулах, мод үржүүлгийн газар байгуулах иргэн аж ахуйн нэгжид олгохоор тусгаж 100 орчим га талбайг мод үржүүлэг, ойн зурвас, ногоон байгууламж байгуулах зориулалтаар олгосон байна.	
1.3.4	Мод, сөөгийн тарьц, суулгацын нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;	-	Мод, сөөгийн тарьц, суулгацын нөөц бүрдүүлсэн байх	2022 онд аймгийн хэмжээнд 2,0 сая тарьц суулгацны нөөц бүрдүүлсэн.	-Шилмүүст модны тарьц, суулгац 150,000-аас доошгүй, -Навчит модны тарьц, суулгац-300,000-аас доошгүй тарьц ургуулсан байх	-2023 онд улсын хэмжээнд мод үржүүлгийн газруудын бүртгэл тооллого зохион байгуулагдаж Өвөрхангай аймагт хийгдсэн тооллогоор тус аймгийн Арвайхээр, Тарагт, Зүүнбаян-Улаан, Баруунбаян-Улаан, Хужирт, Хархорин, Бат-Өлзий сумдад мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 17 аж ахуйн нэгж, байгууллага, иргэн уг тооллогод хамрагдсан. Эдгээр мод үржүүлгийн газруудад 20 гаруй нэр төрлийн 5.7 сая орчим тарьц суулгац байгаагаас ирэх онд ойжуулалт, цэцэрлэгжүүлэлтэд шилжүүлэх боломжтой 2-с дээш настай 1.2 сая тарьц суулгац ургуулж нөөц бүрдсэн.	100
1.3.5	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулах;	-	“Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд тарьсан модны тоо, ургалтын хувь	2022 онд 320 гаруй мянган мод тарьсан.	Аймгийн хэмжээнд 800.0000 мянган мод тарьсан байх	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 оны бүх нийтээр мод тарих хаврын өдрийг Өвөрхангай аймагт 2023 оны 05 сарын 12-ноос эхлүүлж тарьц суулгац нийлүүлэх үзэсгэлэн худалдааг Арвайхээр, Хархорин сумдад зохион байгууллаа. Энэ жилийн бүх нийтээр мод тарих өдрийг төв суурин газрын айл өрхүүдийг оршин суугаа хашаандаа мод тариулах, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Өрх бүр хашаандаа мод тарьцгаая” уриалга өрнүүлж зохион байгуулж байна. 2023	50

						оны 10 сарын 15-ны байдлаар тус аймагт 326,800 орчим мод бут тарьсан.	
1.3.6	Ойжуулалт, ойн зурвас байгуулах ажил гүйцэтгэх;	ОНТ 240.6	Өөрийн хөрөнгөөр ойжуулалт хийгдсэн эсэх;	2022 онд өөрийн хөрөнгөөр 10 га талбайд, улс, орон нутгийн нутгийн төсвөөр 20 га ойн зурвас байгуулах ажил хийгдсэн.	2023 онд өөрийн хөрөнгөөр ойжуулалт-20 га-аас доошгүй, БСУТАжил-15 га, орон нутгийн төсвөөр ойжуулалт-5 га, ойн зурвас-20 га-д хийх	-Ойн газар, “Тэрбум мод” сангаас зарлагдсан сонгон шалгаруулалтад шалгарсан “Их сумт хайрхан” ХХК Бат-Өлзий сумын Хойд агуйт, Баянзураад ойжуулалт 28 га, ойгоос мод бэлтгэсэн аж ахуйн нэгж нөхөрлөлүүд өөрийн хөрөнгөөр 12 га ойжуулалт, байгалийн сэргэн ургалтад туслах ажил 15 га-д тус тус хийсэн. Орон нутгийн төсвөөр Зүүнбаян-Улаан сум ойжуулалт 3 га, бусад сумдад ойн зурвас 14 га, төв суурин газарт шинээр байгуулсан ногоон байгууламж 35 га талбайд мод тарьсан. -Ойн зурвас байгуулах ажил улсын төсвийн хөрөнгөөр тал хээр говийн бүсийн хамгаалалтын ойн зурвас байгуулах ажил Баян-Өндөр суманд 10 га, Баруунбаян-Улаан суманд 8 га, Баянгол суманд 8 га тус тус хийгдсэн. Аймгийн хэмжээгээр ойжуулалт 43 га, байгалийн сэргэн ургалтад туслах ажил 15 га, ойн зурвас 40 га, шинээр байгуулсан ногоон байгууламж 35 га, “Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд тарьсан модны тоо 10 сарын 25-ны байдлаар 326,800 ширхэг мод бут тарьж, намрын тооллогоор 80 хувийн ургалттай байна.	100
1.3.7	Ойн хөнөөлт шавьжтай тэмцэх устгал тэмцлийн ажил гүйцэтгэх;	ОНТ 409.5	Үүргийн шүршигч багаж ашиглан химийн аргаар тэмцэх ажлын хэмжээ	2022 онд 3800 га талбайд хортон устгалын ажил хийгдсэн.	Хортон устгалын ажил 9115 га-аас доошгүй талбайд хийгдсэн байх	-Бат-Өлзий, Хужирт, Хархорин сумдын ойн санд хийгдэх хөнөөлт шавжийн устгал тэмцлийн ажлын сонгон шалгаруулалтад “Гранд-Форест”, “Хатант Форест” ХХКомпаниуд шалгарч 2023 оны 06 дугаар сарын 16-наас 07 сарын 20 хүртэл хугацаанд яacobсоны төөлүүрч, шинэсний шилмүүс хуйлагч эрвээхэйн хөнөөлийн голомт илэрсэн талбайд утаат үүргийн шүршигч багаж ашиглан химийн аргаар	100

						<p>устгал тэмцлийн ажлыг зохион байгууллаа. Дээрх аж ахуйн нэгжүүд Хархорин суманд 600, Хужирт суманд 1337, Бат-Өлзий суманд 7407, Уянга суманд 180, Хайрхандулаан суманд 125, Зүүнбаян-Улаан суманд 1500 га, нийт 11,149 га талбайд устгал тэмцлийн ажлыг гүйцэтгэж үүнд орон нутгийн төсвөөс буюу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 407.2 сая төгрөг зарцуулсан байна.</p> <p>-Тус аймагт “Эрүүл ой” төслийн хүрээнд хэрэгжиж байгаа улсын төсвөөр хийгдэх ойн хөнөөлт шавжийн устгал тэмцлийн ажлыг 2023 оны 08 сарын 10-18-ны хугацаанд хийгдсэн. Уг ажлыг Бат-Өлзий суманд 16000 га, Хужирт суманд 2000 га, Хархорин суманд 2000 га нийт 20,000 га талбайд авиа химийн аргаар гүйцэтгэлээ.</p>	
1.3.8	Төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх;	ОНТ 125.5	Шинээр нэмэгдсэн ногоон байгууламжийн хэмжээ	2022 онд 31 га ногоон байгууламж нэмэгдсэн	Аймгийн нийт ногоон байгууламжийн хэмжээ 190 га-д хүргэх	<p>-Арвайхээр суманд мод тарих төвлөрсөн байршил болох 23 га талбай бүхий “Баян намсрай” цэцэрлэгт хүрээлэнг шинээр байгуулж энэ жилийн мод тарих өдрүүдээр 130 гаруй байгууллага, аж ахуйн нэгжүүдийн 2800 гаруй ажилчид, албан хаагчид 10,500 орчим мод тарилаа. Энэхүү цэцэрлэгт хүрээлэнд мод тарихад Арвайхээр сумын Гандан пунцоглин хийдийн лам нар оролцож цаашид сүсэгтэн олон, иргэдээр буяны зорилгоор мод тариулж байх, мод тарих соёлыг бүх нийтийн үйлс болгож түгээн дэлгэрүүлэх ажлыг хамтарч зохион байгуулж ажиллах юм.</p> <p>-Сумдаас ирүүлсэн мэдээллээр 2023 онд шинээр байгуулах ногоон байгууламж 35 га талбайгаар нэмэгдлээ. Төв суурин газрын ногоон байгууламж нэмэгдүүлэх</p>	100

						ажилд сумдын орон нутаг хөжүүлэх сан болон байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 540,0 сая төгрөг зарцуулсан байна.	
1.3.9	Сум дундын Ойн ангийн мод үржүүлгийн газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж тарьц, суулгацын нөөцийг нэмэгдүүлэх;	ОНТ 37.5	Тарьц, суулгацын нөөцийг нэмэгдүүлсэн эсэх	Ой ангийн мод үржүүлгийн газарт 2022 онд орон нутгийн төсвөөс 16,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	2023 онд 450.000-аас доошгүй тарьц суулгац ургуулах	2023 онд Сум дундын Ойн ангийн мод үржүүлгийн газрыг 3 га талбайгаар өргөтгөж хөрс боловсруулах, тарьц суулгац ургуулах ажил төлөвлөгөөний дагуу бүрэн хийгдлээ. Мод үржүүлгийн газарт шаардлагатай үр, мөчир бэлтгэх, бордоо, ариутгалын бодис, хүлэмж, усалтын систем авах, гэрээт ажилтан ажиллуулах зэрэг ажилд дэмжлэг үзүүлж Бат-Өлзий сумын орон нутгийн төсөв байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 30,0 сая төгрөгийн санхүүжилт олголоо. Улсын хэмжээнд явагдсан мод үржүүлгийн газрын бүртгэл тооллогоор Сум дундын Ойн ангийн мод үржүүлгийн газарт 2023 оны байдлаар 1300.0 мянга орчим ширхэг тарьц суулгац ургуулж байна. Сум дундын Ой анги улсын төсвийн санхүүжилтээр эх ургамлын плантаци байгуулах, ойн үрийн талбай арчлах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.	100
Зорилт 1.4 Уялдаа: АЗДҮАМХ 4.1.3.1-3.4		Усны нөөцийн ашиглалт, хамгаалалт					
1.4.1	Булаг шанд, рашааны эхийг хамгаалах;	ОНТ 25.0	Хамгаалсан булаг шандны тоогоор	2022 онд 29 булаг шанд, рашааны эхийг хашиж хамгаалсан	Аймгийн хэмжээнд 15-аас доошгүй булаг шандны эхийг хамгаалж, нутгийн иргэдэд хариуцуулсан байна.	Булаг шанд, рашааны эхийг хашиж, хамгаалах материал нийлүүлэх аж ахуйн нэгжийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар тендерийн материалыг боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 3 удаа зарлаж “Их дөлгөөн хангай” ХХК шалгарч 09 дүгээр сарын 13-ны өдөр булаг шандны эх хашиж хамгаалах материал нийлүүлэх гэрээг байгуулан 800 ширхэг шургааг, 160 ширхэг арматурын төмөр нийлүүлсэн.	100

						Энэ онд Баян-Өндар суманд 4, Бүрд суманд 2, Баянгол суманд 2, Өлзийт суманд 3, Тарагт суманд 2 булаг, Богд суманд 1, Нарийнтээл суманд 3, Хайрхандулаан суманд 1 булгийг хашиж хамгаалахаар судалгааг гарган материалыг сумдад хүргүүлэн гурвалсан гэрээ байгуулан ажиллаж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг бууруулах үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн манлайлал төслөөс Арвайхээр сумын Бурхийн эхийг хашиж хамгаалсан тус ажлын хүрээнд мэдээллийн самбар байршуулж хамтран ажилласан.	
1.4.2	Газрын доорх усны мониторингийн цооногт мэдээлэл дамжуулах хагас автомат багаж суурилуулах;	ОНТ 10,0	Хяналтын цооногт стандартын шаардлага хангасан багаж суурилуулсан эсэх	Арвайхээр суманд 3, Бүрд суманд 1 хяналтын цооногтой	Стандартын шаардлага хангасан багаж суурилуулсан байна.	-Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар Хужирт сумын халуун рашааны хэрэглээ, чанарыг хянах зорилгоор мониторингийн цооногт автомат багаж суурилуулах ажлын хүрээнд КРМ ХХК-тай тоног төхөөрөмж худалдан авах, суурилуулах гэрээ байгуулан рашааны мониторингийн цооногт усны түвшин, температур хянах зориулалт бүхий TD-Diver Datalogger суурилуулж www.groundwater.mn улсын нэгдсэн системд холбуулсан. Тус багаж нь онлайн горимоор ажиллаж хоногт 4 удаагийн мэдээг хурааж улсын мэдээллийн системд тогтмол мэдээлж байхаар тохируулга хийгдсэн.	100
1.4.3	Томоохон голын дагуух хөрс, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээ зохион байгуулах, Дэлгэрэх голын	ОНТ 20.0	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	Томоохон голуудын орчны бохирдлыг бүрэн цэвэрлэсэн.	Томоохон голуудын дагуух хөрс орчны бохирдлоос урьчилан сэргийлэх арга	-Томоохон голын дагуух хөрс, орчны бохирдлыг бууруулах зорилтын хүрээнд “Цаг гаргая” аян, “Явган аялал”-ын тэмцээнийг зохион байгуулж, тэмцээний үеэр хээрийн цай амттай, олс таталт, Дайргын гол дагуух хог түүх марафон тэмцээнүүдийг зохион байгуулж 70 гаруй	100

	голдрилыг сэргээн засварлах;				хэмжээ зохион байгуулсан байна.	шуудай хог хаягдлыг цэвэрлэж хогийн нэгдсэн цэгт хүргэсэн. -Зэвсэгт хүчний 256-р анги, Онги-Таац голын сав газрын захиргаатай хамтран 2023 оны 06 сарын 26-ны өдрөөс 30-ны өдрүүдийн хооронд Онги, Дайргын гол орчмыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж, 20 гаруй тн хог хаягдлыг цэвэрлэж хогийн нэгдсэн цэгт хүргэх ажлыг зохион байгуулсан. -Дэлгэрэх голын голдирол үерийн усны нөлөөгөөр эвдэрч гэмтэхээс хамгаалах үүднээс хөвийн дарагдсан лаг хагшаасыг цэвэрлэх, инженерийн байгууламж, суваг хоолойг хэвийн үйл ажиллагаанд оруулж, цаашдын ашиглалтыг сайжруулах зорилгоор Арвайхээр сумын ЗДТГ, Онги-Таац голын сав газрын захиргаа хамтран 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн хөв цөөрмийн лагийг цэвэрлэх ажлыг хамтран зохион байгуулсан. Тус ажлын гүйцэтгэгчээр “Арвайхээр тохижилт, үйлчилгээ” ОНӨААТҮГ ажиллаж нийт 2360м3 лагийг ачиж, зөөж тээвэрлэн Арвайхээр сумын хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэж, хог хаягдлыг дарж булшлан, 1,2 га газарт техникийн нөхөн сэргээлт хийсэн.	
1.4.4	Усан сан бүхий газарт идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах, ажлын үр дүнгээр урамшуулах, тэдний мэдлэг чадварыг дээшлүүлэх;	ОНТ 14.0	Идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах журмын хэрэгжилтийг хангаж ажиллах.	-	Шаардлагатай сумдад идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулж, урамшуулан чадавхижуулах ажлыг зохион байгуулна.	Усан сан бүхий газарт 3 идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулж, одоо ажиллаж буй идэвхтэн байгаль хамгаалагчийн судалгааг гарган, тэдэнд шинээр гарсан хууль, дүрэм, журмыг танилцуулах мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтыг 12 сард зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хийж байна. Хэрэгжилт тооцох боломжгүй.	-
1.4.5	Байгаль орчныг хамгаалах багц хууль,		Хууль тогтоомж,	2022 онд холбогдох хуулийн	Байгаль орчныг хамгаалах тухай,	-Аймгийн ГХУСАЗСалбар зөвлөл, Прокурорын газартай хамтран сумдын	100

	<p>усны талаарх хууль тогтоомж болон тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах, хяналт, шалгалт зохион байгуулах;</p>	<p>ОНТ 20.0</p>	<p>тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангагдсан эсэх</p>	<p>хүрээнд ажиллагаа явуулсан. үйл</p>	<p>усны талаарх хууль тогтоомж болон тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах хүрээнд байгаль орчны хяналт шалгалтын ажил зохион байгуулсан байна.</p>	<p>байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчдад нэгдсэн сургалт семинарыг зохион байгуулж, байгаль орчны хууль тогтоомж, шинээр гарсан дүрэм журмууд, зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа, байгаль орчны эсрэг гэмт хэргийг бууруулах талаар сургалт мэдээлэл хийсэн.</p> <p>-Төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд Хужирт сумын рашаан сувиллын газруудад байгаль орчинд бохирдол доройтол үүсгэж байгаа эсэхэд хяналт шалгалт 2023 оны 04 дүгээр сарын 10-12-ны өдрүүдэд хийлээ.</p> <p>- Хяналт шалгалтад “Хужирт рашаан сувилал” ХХК, “Элма Хужирт” ХХК, “Ананд Хужирт” ХХК, “Тө Ба Сэ” ХХК, “Газарчин Хужирт” ХХК-иуд хамрагдлаа. Шалгалтаар “Хужирт рашаан сувилал” ХХК-ийн цэвэрлэх байгууламжаас гарч байгаа хаягдал бохир усны дээжийг Ус, цаг уурын орчны шинжилгээний төвийн магадлан итгэмжлэгдсэн лабораторид, рашаан сувиллын газруудын үйл ажиллагаанаас хөрс бохирдол үүсгэж байгаа эсэхийг тогтоохоор 3 цэгээс хөрсний дээж авч, аймгийн Стандарт хэмжил зүйн газрын магадлан итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлсэн. Шинжилгээний дүнгээр бохир усны дээж нь “Усны чанар, хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэрлэгдсэн бохир ус Ерөнхий шаардлага” MNS 4943-2015 стандартын шаардлага хангаагүй, хөрсний шинжилгээний хариу бага зэргийн бохирдолтой гэж гарсан тул улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн.</p>
--	--	---------------------	---	--	--	--

1.4.6	Усны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4-т заасны дагуу усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс, ус хангамжийн эх үүсвэрийн тэжээгдлийн мужийн заагийг ИТХ-аар тогтоож, Хууль зүйн яаманд бүртгүүлж, дэглэмийг мөрдүүлэх;	ОНТ 19.0	17 сумын усны тоо бүртгэлийг хийж, усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг тогтоож, тэмдэгжүүлнэ.	2 сумын усны тоо бүртгэлийг хийж, усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг тогтоож, тэмдэгжүүлсэн.	Усны тооллогыг хийж, усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг тогтоож, усны мэдээллийн сангийн мэдээллийг шинэчилнэ.	Өвөрхангай аймгийн засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/417 захирамжаар “Уст цэгийн тоо бүртгэл хийх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтоох” ажлын хэсэг байгуулагдаж аймгийн 16 суманд 6 дугаар сарын 20-ноос 11 дүгээр сарын 10-ны өдрийн хугацаанд хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэж, хамгаалалтын бүсийн зураглалын ажлыг Arcgis 11.8, Qgis программуудыг ашиглан боловсруулж байна. Тус ажлын хүрээнд гол, булаг, рашаан, худаг, нуур цөөрөм, усны барилга байгууламжуудыг маягтын дагуу судалгааг гаргасан. Тооллогын дүнгээр Өвөрхангай аймагт нийт давхардсан тоогоор 243 гол горхи, 1019 булаг шанд, 110 нуур цөөрөм, 2248 худаг, 10 услалтын систем, 11 хөв цөөрөм бүртгэгдсэн байна.	100
1.4.7	Усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх талаарх иргэд олон нийтийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах;	ОНТ 14.8	Зохион байгуулсан арга хэмжээ, хамрагдсан иргэдийн тоо	2022 онд хэрэгжүүлсэн ажлын мэдээллийг орон нутгийн телевиз, цахим хуудсаар тухай бүр мэдээлсэн.	Үндэсний болон орон нутгийн телевизүүдтэй хамтран ажиллаж, байгаль орчны мэдээ, мэдээллүүдийг иргэд олон нийтэд хүргэх, сургалт сурталчилгааны ажлууд хийгдсэн байна.	-“Дэлхийн усны өдөр”-ийг “Өөрчлөлтийг хурдасгая”, “Дэлхийн байгаль хамгаалах өдөр”-ийг “Хуванцар хог хаягдлын бохирдлын шийдэл” уриан дор тус тус тэмдэглэн өнгөрүүлээ. Тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд аймгийн ЕБС-ийн 1-10 дүгээр ангийн сурагчид, цэцэрлэгийн бэлтгэл, ахлах бүлгийн нийт 400 орчим хүүхдэд “Усны үнэ цэнэ”, “Усыг зүй зохистой ашиглах” талаар сургалтыг тухай бүр зохион байгуулсан. -Усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор Онги-Таац голын сав газрын захиргаатай “Эко-Эргүүл” арга хэмжээг зохион байгуулах ажлын гэрээг байгуулан 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрөөс 10 дугаар сарын 01-ны өдрийг хүртэл хугацаанд 7 хоног бүр хуваарь	100

						гарган арга хэмжээг зохион байгуулсан. Тус ажлын хүрээнд Онги, Дайрга, Орхон, Орхоны хүрхрээ, Таацын гол дагуу нийт 45 өдрийн хугацаанд 1000 гаруй тээврийн хэрэгсэл, 4700 гаруй иргэнд ил задгай хог хаягдал хаяхгүй байх, үер усны аюулаас сэргийлэх талаар мэдээлэл өгч 1500 гаруй гарын авлага тарааж Онги, Дайргын гол дагуух усны сан бүхий газрын тэмдэгжүүлэлтийн самбаруудыг шинэчилсэн.	
1.4.8	Хөв цөөрөм байгуулах зураг төсөв хийлгэх;	ОНТ 25.0	Хөв цөөрмийн зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх.	2022 онд Нарийнтээл суманд байгуулах хөвийн зураг, төсвийг батлуулсан.	Хөвийн зураг төсөв хийлгэсэн байна.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын нутагт орших хөв цөөрмийг шинэтгэн засварлах ажлын зураг төсөл боловсруулах ажлын даалгавар, тендерийн жишиг баримт бичгийг боловсруулан www.tender.gov.mn цахим хаягт нээлттэйгээр байршуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаад байна.	70
1.4.9	Ус бохирдуулагчийн эх үүсвэрийн тооллого хийх;	-	Аймгийн хэмжээнд тооллогыг зохион байгуулна.	-	Ус бохирдуулагчийн эх үүсвэрийн тооллогын зохион байгуулж дүн мэдээг нэгтгэсэн байна.	Уст цэгийн тоо бүртгэл хийх, усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс тогтоох ажлын хүрээнд сумын төвүүдэд үйл ажиллагаа явуулж буй ус бохирдуулагчийн тоог нарийвчлан гаргасан бөгөөд аймгийн хэмжээнд 722 иргэн, ААН үйл ажиллагаа явуулж байна. 2023 онд 140 аж ахуйн нэгж хаягдал усны дүгнэлт гаргуулан ус бохирдуулсны төлбөрт 3,963,068 төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.	100
Зорилт 1.5 Уялдаа: АЗДҮАМХ 4.1.2.1-2.4		Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийг хамгаалах талаар:					

1.5.1	<p>Хог хаягдлын менежментийг сайжруулж, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах дадал хэвшлийг бий болгож, байгальд хаягдах хог хаягдлын хэмжээг бууруулах, хог хаягдал цэвэрлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.</p>	ОНТ 40.0	<p>-Ангилан ялгаж нийлүүлсэн дахивар бүтээгдэхүүний хэмжээ</p> <p>-Цэвэрлэгээ зохион байгуулсан ажлын тоо</p>	<p>-Эх үүсвэр дээр нь ангилан ялгасан хог хаягдлын хэмжээ 301,8 тн</p> <p>-Бүх нийтийн их цэвэрлэгээгээр 7096 тонн хог хаягдал</p>	<p>-Ангилан ялгасан хог хаягдлын хэмжээг нийт хог хаягдлын 5 хувьд хүргэх.</p> <p>-Аймгийн хэмжээнд улирал бүр “Бүх нийтийн цэвэрлэгээ”-ний ажлыг зохион байгуулж, дүн мэдээг нэгтгэсэн байх</p>	<p>Засгийн газраас 2023-2025 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан Байгаль орчин аялал жуулчлалын сайдын “Эрүүл аюулгүй Цэвэр орчин” бүрдүүлэх арга хэмжээний тухай 02, 05 дугаар албан даалгавруудын хэрэгжилтийн хүрээнд аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 1/110 тоот албан бичгээр сумдад чиглэл хүргүүлсэн. Тус албан даалгаврын хэрэгжилтийн хүрээнд сумдууд улирал бүр нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж хэвшсэн бөгөөд жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 500 гаруй тн хог хаягдал, 28 гаруй тн зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг устгах, уст цэг, усны эх үүсвэрийг хамгаалах, бохирдохоос сэргийлэх арга хэмжээг авч ажилласан.</p> <p>-Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, дахин ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулах ажлын хүрээнд аймгийн хэмжээнд 13 сум хоёрдогч түүхий эд пресслэх 20 төхөөрөмжтэй болж, иргэдтэй гэрээ байгуулан иргэдийг ажлын байраар хангаж, сумын төвдөө хог хаягдлыг ангилан ялгаж дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг пресслэн аймгийн төв болон Улаанбаатар хотын хоёрдогч түүхий эд бэлтгэн нийлүүлэх төвд нийлүүлж байна. 2022-2023 онд 70 гаруй тн дахивар цуглуулж орчны бохирдол үүсэхээс урьдчилан сэргийлсэн байна.</p>	100
1.5.2	<p>Орон нутагт газар ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад байгаль орчинд ээлтэй</p>	-	<p>Зохион байгуулсан сургалт, нөлөөллийн</p>	<p>2022 онд хог хаягдлыг ангилан ялгах дадал хэвшлийг төлөвшүүлэх,</p>	<p>Аймгийн төв, сумдын хэмжээнд сургалт, нөлөөллийн ажлыг үе шаттайгаар зохион байгуулсан байна.</p>	<p>“Монголд зочлох жил”-ийн хүрээнд Хог хаягдлын тухай хууль, БОАЖ-ын сайдын 2023 оны 02 албан даалгаварын хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион</p>	100

	<p>хэрэглээний соёл хэвшүүлэх, хог хаягдлыг ангилан ялгах дадал зуршлыг төлөвшүүлэх, хүний эрүүл мэнд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар сургалт, семинарыг үе шаттайгаар зохион байгуулах;</p>		<p>арга хэмжээгээр</p>	<p>хүний эрүүл мэнд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр иргэд, өсвөр үеийнхэнд зориулсан сургалтыг 14 удаа зохион байгуулсан.</p>		<p>байгуулж улсын чанартай авто зам дагуу сумдын удирдлага, үйлчилгээ эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж байгууллага, үйлчилгээний газрууд, шатахуун түгээх станцуудад Засгийн газар, БОАЖЯ, орон нутгаас хэрэгжүүлж байгаа бодлого арга хэмжээ, хог хаягдлыг ангилан ялгах дадал зуршлыг төлөвшүүлэх, стандартын шаардлага хангаагүй нүхэн жорлонг буулгах, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар иргэдэд үйлчлэх, хүний эрүүл мэнд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар мэдээлэл, зөвлөмж өгсөн.</p> <p>-Сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нарын нэгдсэн сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулж “Орчны бохирдлыг бууруулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар” сумдад авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл хүргэсэн.</p> <p>-Өвөрхангай аймгийн төрийн бус байгууллагуудын нэгдсэн холбоо “Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг сааруулах ба дасан зохицох чадавхыг нэмэгдүүлэх нь” зөвлөлдөх уулзалтад Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг байгаль орчны салбараас авч хэрэгжүүлж буй бодлого, чиглэлийн талаар мэдээлэл өгсөн тус уулзалтад Арвайхээр сумын багийн Засаг дарга нар, тариаланч малчдын төлөөлөл 60 гаруй иргэд, төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл оролцсон. “Хогоо ангилж хэвшье”, “Нүхэн жорлонгоо стандартын болгоё” 100 ширхэг гарын авлага, “Байгальд ээлтэй аялъя”, “Хогийг хогийн саванд нь”, “Хуванцарын түүх”</p>
--	---	--	------------------------	---	--	--

						богино хэмжээний шторкууд бэлтгэн байгууллагын цахим хуудас болон, хот хоорондын нийтийн тээврээр зорчиж буй зорчигч, иргэдэд тогтмол хүргэн ажиллаж байна.	
1.5.3	Аймгийн хэмжээнд байгаа нүхэн жорлонгийн тооллогын ажлыг зохион байгуулах;	-	Тооллогын дүнгээр	2022 онд усны сан бүхий газарт байрлах нүхэн жорлонгийн судалгааг гаргасан.	Аймгийн хэмжээнд байгаа нүхэн жорлонгийн судалгаа гаргаж дүн мэдээг Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороонд хүргүүлсэн байна.	Аймгийн хэмжээнд нүхэн жорлонгийн судалгааг нэгтгэн гаргах зорилгоор 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 28 дугаар албан бичгийг сумдад хүргүүлэн ирсэн судалгааг нэгтгэн гаргаж мэдээллийн сан үүсгэсэн. Тооллогын дүнгээр аймгийн хэмжээнд 12574 нүхэн жорлон, 457 эко жорлон байгаа судалгаа гарсан.	100
1.5.4	Арвайхээр сумын гэр хорооллыг сайжруулсан шахмал түлшээр хангаж, агаарын бохирдлыг бууруулах;	УТ 2000.0	Сайжруулсан шахмал түлшээр хангагдсан айл өрхийн тоо	2022 онд Арвайхээр сумын Эмтийн 2 дугаар багийн 400-500 айл өрх сайжруулсан шахмал түлш хэрэглэж байна.	Гэр хорооллын айл өрхийн 50 хувийг сайжруулсан шахмал түлшээр хангаж агаарын бохирдлыг бууруулна.	Хугацаа болоогүй	-
1.5.5	Гүний усны болон хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр гэр хороолол, албан байгууллага, жуулчны баазуудын нүхэн жорлонг хөрсөнд нэвчилтгүй эко байгууламжаар солих, шинэчлэх ажлын хүрээнд “Ногоон зээл”-ийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, иргэд, ААН-үүдэд мэдээлэл түгээх, сурталчилгаа явуулах, ажлыг холбогдох	-	Эко ариун цэврийн байгууламжийг нэмэгдүүлсэн байдал Сурталчилгаа, мэдээлэл түгээсэн байдал	2022 онд иргэд өөрсдийн санаачилгаар нүхэн жорлонгоо сайжруулж, хөрсөнд үл нэвчих 1043 ширхэг ариун цэврийн байгууламжийг шинээр байгуулсан байна.	Гэр хороолол, албан байгууллага, жуулчны баазуудын эко ариун цэврийн байгууламжийн тоо нэмэгдсэн байна.	“Монголд зочлох жил”-ийн хүрээнд БОАЖ-ын сайдын 02 дугаар албан даалгавар, Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулж, улсын чанартай авто зам дагуу үйлчилгээ эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж байгууллага, үйлчилгээний газрууд, шатахуун түгээх станцуудад холбогдох хууль тогтоомж, стандартуудыг танилцуулж, хог хаягдлыг ангилан ялгах дадал зуршлыг төлөвшүүлэх, стандартын шаардлага хангаагүй нүхэн жорлонг буулгах, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар иргэдэд үйлчлэх, хүний эрүүл мэнд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг	100

	газруудтай хамтран зохион байгуулах;					бууруулах, байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлэх ногоон зээлийн сангийн талаарх мэдээлэл, зөвлөмжийг өгсөн. Мөн байгууллагын цахим хуудас, орон нутгийн мэдээллийн хэрэслэлүүдээр дамжуулан “Ногоон зээл”, байгаль орчинд ээлтэй технологийн шийдлүүдийн талаарх мэдээллүүдийг түгээх ажлыг тогтмол зохион байгуулж байна.	
1.5.6	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах үйл ажиллагааг дэмжих, сумдыг дахивар бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх боломжоор хангах;	ОНТ 10.0	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	Есөнзүйл, Гучин-Ус, Баян-Өндөр, Уянга, Бүрд, Арвайхээр сумд 2022 онд орон нутгийн хөгжлийн сангийн 69,0 сая төгрөгийн хөрөнгөөр хоёрдогч түүхий эдийг нягтруулах пресслэгч төхөөрөмжийг худалдан авч, аймгийн хэмжээнд 12 сум, 19 пресслэх төхөөрөмжтэй болсон.	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах чиглэлээр иргэдийн мэдлэг хандлага дээшилж, зарим сумдад хоёрдогч түүхий эд нягтруулж, пресслэх төхөөрөмжтэй болж пресслэх төхөөрөмжүүдийн ашиглалт сайжирсан байна.	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах үйл ажиллагааг дэмжих зорилгоор Өлзийт, Тарагт сумд орон нутгийн төсвийн 9,5 сая төгрөгөөр хоёрдогч түүхий эд пресслэх төхөөрөмж худалдан авч хоёрдогч түүхий эд бэлтгэн нийлүүлэх боломжтой болсон. Ингэснээр аймгийн хэмжээнд 14 сум хоёрдогч түүхий эд пресслэх 20 төхөөрөмжтэй болсон.	100
1.5.7	Аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулахын менежментийг хариуцах байгууллагыг сонгон шалгаруулах;	-	Сонгон шалгаруулсан эсэх	Агуулахын байр ашиглалтад ороогүй.	Сонгон шалгаруулалтад хяналт тавьж ажилласан байна.	Барилгын ажил дуусаагүй тул менежментийг хариуцах байгууллагыг шалгаруулаагүй байна. Хэрэгжилт тооцох боломжгүй.	-
1.5.8	Аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулахыг барьж дуусгаж, хэвийн	-	Агуулахын барилгыг хүлээн авсан байна.	Агуулахын барилгын ажил 70 хувьтай явагдаж байгаа	Аюултай хог хаягдлын түр хадгалах агуулахын хэвийн үйл	-Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос манай аймагт зарлагдсан “Аюултай хог хаягдлыг хадгалах, агуулахын жишиг зураг, төсөв	

	үйл ажиллагааг хангах нөхцлийг бүрүүлэх;				ажиллагаа хангагдсан байна.	боловсруулж батлуулах, стандартын шаардлага хангасан аюултай хог хаягдлын агуулахыг барих” нээлттэй тендерийн гүйцэтгэгчээр “ЖАМ” ХХК шалгаран орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны ажлын албатай 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн ОББҮХ/136 дугаартай гэрээ байгуулан барилгын ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд тус барилгын ажил 70 хувьтай баригдаж түр зогссон байдалтай байна. Тухайн барилгын ажлын чанарт анхаарч, яаралтай ашиглалтад оруулах талаар Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороонд 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 69 тоот албан бичгээр хүргүүлсэн.	70
1.5.9	Сумын төвүүдэд хог хаягдлын гуравдугаар зэрэглэлийн төвлөрсөн цэгийн ландфилл байгуулах;	ОНТ 317.0	2-оос доошгүй сумын төвлөрсөн цэгийг шинэчилсэн эсэх	Хархорин, Баян-өндөр, сумдууд хог хаягдлын төвлөрсөн цэгийг дарж газрыг чөлөөлсөн.	Сумдууд хог хаягдлын төвлөрсөн цэгийн талбайн хэмжээг багасгаж, тохижуулсан байна.	-Баянгол сум орон нутгийн төсвийн 92,429.700 төгрөгийн тендер зарлан гүйцэтгэгчээр “Тулгат-Ирээдүй Ундарга” ХХК шалгаран сумын төвд хуримтлагдсан элсийг зөөх, Онгийн гол дагуу үүссэн хайрганы нүхийг нөхөн сэргээх, хуучин хогийн цэгийг зөөж, тэгшлэх, шинээр хогийн цэг байгуулах байгуулах ажлыг гүйцэтгэж байна. Тарагт сум орон нутгийн төсвийн 50,0 сая төгрөгийн тендер зарлан сумын төвийн нэгдсэн 2 га талбай бүхий хогийн цэгийн хогийг түрж булшлах, талбайн хэмжээг багасгах, хашаажуулах, хоёрдогч түүхий эд пресслэх төхөөрөмж нийлүүлэх ажлын тендер зарлаж, “Бүргэдэй Хайрхан” ХХК шалгаран ажлыг гүйцэтгэсэн.	100
1.5.10	Амьтны амьдрах орчныг сайжруулах, нэн ховор, ховор амьтанд биотехникийн арга хэмжээ авах;	ОНТ 85.4	Биотехникийн арга хэмжээг зохион байгуулсан үр дүн, давтамж, тоо хэмжээгээр	2022 онд нийт 14 сумын 58 цэгт өвс, хужир тавьж тус ажилд сумдын БОХУБайцаагч, байгаль орчны	Богд, Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Хайрхандулаан, Уянга, Зүүнбаян-Улаан, Хужирт, Хархорин, Есөнзүйл,	-2023 онд нийт 15 сумын 94 цэгт 5000 боодол өвс, 8 тонн хужрыг нэн ховор болон ховор амьтад болох аргаль, янгир, халиун буганд тавьж өгөх ажлыг холбогдох сумдын ЗДТГазар, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Байгаль	100

				асуудал хариуцсан мэргэжилтнүүд, байгаль хамгаалагчид, нөхөрлөлийн гишүүд хамтран зохион байгууллаа.	Бүрд, Гучин-Ус, Төгрөг, Баян-Өндөр, Өлзийт сумд биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, батлагдсан төсвийн дагуу нэн ховор, ховор амьтдад биотехникийн арга хэмжээг зохион байгуулсан байна.	хамгаалагч, нөхөрлөлийн гишүүдтэй хамтран хийж гүйцэтгэсэн.	
1.5.11	Аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах;	ОНТ 35.0	Ан бүхий 14 суманд	2018 онд мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, аймгийн ИТХурлын Тэргүүлэгчдийн хурлаар 2018 оны 65 дугаар тогтоолоор батлуулсан.	Ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж аймгийн ИТХ-аар батлуулсан байна.	-Өвөрхангай аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгаа, 2024-2028 онд хэрэгжүүлэх ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлын зөвлөх үйлчилгээний тендерийг зарлаж, "Авралын эрэлд" ХХК шалгарсан. Хээрийн судалгааг 2023 оны 08 сарын 04-28-ыг хүртэл хугацаанд ан амьтад бүхий 17 сумыг хамруулан хийж, 09 сарын 11-ний өдөр сумдын Засаг дарга, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчдад судалгааны ажлын үр дүнг танилцуулж санал авах хэлэлцүүлэг зохион байгуулж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан, аймгийн ИТХ-ын 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 22/03 дугаар тогтоолоор Ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгааны тайлан, аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөний төслийг дэмжсэн тогтоол гарч, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлээд байна.	100
1.5.12	Тарвага сэргээн нутагшуулах ажлыг зохион байгуулах;	ОНТ 49.0	3 суманд 100-аас доошгүй	-	Сант, Есөнзүйл, Бүрд суманд тарвага	Есөнзүйл сумын Хайрханы 3 дугаар багийн нутаг Жинэгэр, Улаан чулуут гэдэг газар 25 толгой тарвага сэргээн	-

			тарвага нутагшуулна.		сэргээн нутагшуулсан байна.	нутагшуулсан. Тус ажлыг 2023 оны 07 сарын 9-10-ны өдрүүдэд ХААИС-ийн судлаачид хийж гүйцэтгэсэн. Тарваганы нөөц бүхий аймгууд, тарвага сэргээн нутагшуулах зөвшөөрөл олгоогүй тул Сант, Бүрд суманд тус ажил хийгдээгүй.	
1.5.13	Идлэг шонхор болон бусад махчин шувуудыг өндөр хүчдэлд цохиулж эрсдэхээс хамгаалж, хиймэл үүр, шувууны суудал хийж шаардлагатай газруудад байршуулах;	ОНТ 65.0	8 суманд	-	Есөнзүйл, Баян-Өндөр, Сант, Хайрхандулаан, Хужирт, Хархорин, Гучин-Ус суманд идлэг шонхор болон бусад махчин шувуудыг өндөр хүчдэлд цохиулж эрсдэхээс хамгаалж, хиймэл үүр, шувууны суудал хийж шаардлагатай газруудад байршуулсан байна.	Идлэг шонхор болон бусад махчин шувуудыг өндөр хүчдэлд цохиулж эрсдэхээс хамгаалж, тус аймгийн Баян-Өндөр суманд 100 ширхэг, Тарагт, Хайрхандулаан чиглэлийн ЭБЦТСтанцын 10 квт шугмын дагуу 20 ширхэг, Хархорин суманд 50 ширхэг, Гучин-Ус сум 30 ширхэг, Хужирт суманд 140 ширхэг, нийт 340 ширхэг суудал хийж шаардлагатай газруудад байршууллаа.	100
1.5.14	Монгол орны хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлдэг байгаль орчны өдрүүдийг зохион байгуулах.	-	Арга хэмжээний тоогоор	900 гаруй хүүхдүүдэд танин мэдэхүйн сургалт сурталчилгааны ажил зохион байгуулсан.	Тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Бүх нийтээр мод тарих” хаврын өдрийн хүрээнд 05 сарын 12-ны өдөр тарьц суулгац нийлүүлэх үзэсгэлэн худалдааг Арвайхээр, Хархорин сумдад зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдаанд 20 гаруй нэр төрлийн 250.0 орчим мянган тарьц суулгац борлуулсан. Арвайхээр суманд мод тарих төвлөрсөн байршил 23 га талбай бүхий “Баян намсрай” цэцэрлэгт хүрээлэнг шинээр байгуулж энэ жилийн мод тарих өдрүүдээр 130 байгууллага, аж ахуйн нэгжүүдийн 2800 гаруй ажилчид, албан хаагчид өөрсдийн зардлаар 11000 орчим мод тарилаа. Дэлхийн байгаль хамгаалах өдрийн хүрээнд Арвайхээр хотын өнгө үзэмжийг нэмж, хүүхэд залуусыг байгаль	100

						<p>эх дэлхийгээ хайрлахыг уриалсан “Эзэнтэй мод” үйл ажиллагааг 2023 оны 06 сарын 04-ны өдөр зохион байгууллаа. Тус үйл ажиллагаанд Арвайхээр сумын ерөнхий боловсролын Мэргэд, Соёмбо, 1, 4, 5, дугаар сургуулийн Политехник коллежийн 140 сурагч оролцож мод тарьж арчлах, хог хаягдлыг ангилан ялгах чиглэлээр сургалтад хамрагдав.</p> <p>БОАЖГазар, Ирвэс хамгаалах сан хамтран “Цоохор ирвэс хамгаалах” дэлхийн өдрийн хүрээнд 2023 оны 10 дугаар сарын 23-д Арвайхээр сумын ерөнхий боловсролын II дугаар сургуулийн 8-9 дүгээр ангийн 12 бүлгийн 350 сурагчдад “Бид ирвэстэй нутгийн хүүхдүүд” сургалт хийж, ирвэс хамгаалах сангаас боловсруулсан 8 төрлийн гарын авлага, сонин, зөвлөмжийг өгч, явган аялал зохион байгууллаа.</p>	
<p>Зорилт 1.6 Уялдаа: АЗДҮАМХ 4.2.1.1, 4.2.1.3</p>		<p>Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.</p>					
1.6.1	Аялал жуулчлалын дэд хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, батлуулах;	-	Аялал жуулчлалын дэд хөтөлбөрийг батлуулсан эсэх	Аялал жуулчлалын дэд хөтөлбөр 2018-2022 он	Аялал жуулчлалын дэд хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, аймгийн ИТХ-аар батлуулсан байна.	<p>Сумдын ЗДТГазар болон аймгийн аялал жуулчлалын холбоо, аж ахуй нэгжүүдээс аймгийн аялал жуулчлалын дэд хөтөлбөрт тусгах саналуудыг авч, нэгтгэн боловсруулж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар 2 удаа хэлэлцүүлсэн. Гэвч “Аялал жуулчлалын тухай хууль” 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр шинэчлэгдэн батлагдаж, хэрэгжиж эхэлсэн. Тус хуульд улс, орон нутгийн аялал жуулчлалын бүс тогтооно гэж заасны дагуу аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11 сарын 30-ны өдрийн хурлаар аймгийн аялал жуулчлалын бүсийг тогтоосон.</p>	100

1.6.2	Аймгийн аялал жуулчлалын бренд бүтээгдэхүүнийг шалгаруулах;	-	Аялал жуулчлалын бренд бүтээгдэхүүнтэй болсон эсэх;	-	Аялал жуулчлалын бренд бүтээгдэхүүнийг шалгаруулж, сурталчилсан байх.	Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан сум бүрт аялал жуулчлалын маршрут болон брэнд бүтээгдэхүүнтэй болох чиглэлийг аймгийн Засаг даргын албан тоотоор сумдын Засаг дарга нарт хүргүүлж, 12 сум аяллын маршрут болон брэнд бүтээгдэхүүнтэй болсон.	90
1.6.3	Аялал жуулчлалын үйлчилгээний байгуулгуудад зочлох үйлчилгээний төрөлжсөн сургалтыг зохион байгуулж, чанар, стандартыг сайжруулах, хэрэгжилтэд хяналт тавих;	ОНТ 15,0	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	2022 онд 58 иргэн зочлох үйлчилгээний сургалтад хамрагдсан.	150-аас доошгүй иргэд сургалтад хамруулсан байна.	Аймгийн хэмжээнд 2023 оны байдлаар аялал жуулчлалын чиглэлээр 70 гаруй аж ахуй нэгж үйл ажиллагаа эрхэлж, 800 гаруй иргэд энэ салбарт ажиллаж байна. Эдгээр иргэдийг чадавхжуулах зочлох үйлчилгээний сургалтыг төр болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 4 удаа зохион байгуулж, нийт 96 иргэнийг хамруулсан. Аймгийн Политехникийн коллежтой хамтран 2022-2023 оны хичээлийн жилд аяллын хөтөч, зочид буудлын үйлчилгээний ажилтны ангид аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж байгаа орон нутгийн 50 иргэнийг суралцуулах ажлыг зохион байгуулж, 36 иргэнд мэргэжлийн үнэмлэх олгосон. Боловсролын сангаас суралцагчдад 63.0 сая төгрөгийн сургалтын тэтгэлэг олгогдсон. Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчдийн “Аялал жуулчлалын сэргэлт” зөвлөгөөнийг 2023.10.21-ний өдөр зохион байгуулж, аймгийн удирдлагууд, сумдын Засаг дарга нар, БОАЖГазар, ОХБЦГХЗахиргаа болон аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг жуулчны бааз, рашаан сувилал, зочид буудал зэрэг 60 гаруй төлөөлөл оролцож, Орон нутгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг	100

						хөгжүүлэх, Орон нутгийн аялал жуулчлалын бүс тогтоох аргачлал зэрэг сургалтад тус тус хамрагдсан. Дээрх сургалтуудад 2023 оны байдлаар нийт 206 иргэн хамрагдсан.	
1.6.4	“Торгоны зам-Хархорум хот”, “Монгол эсгий урлалын баяр”, “Сарлагын баяр”, “KHARAKHORUM ICE FESTIVAL” эвентүүдийг зохион байгуулах;	ОНТ 60.0	Зохион байгуулсан эвент арга хэмжээний тоо	2022 онд 2 эвент арга хэмжээг зохион байгуулсан.	4-өөс доошгүй эвент арга хэмжээг зохион байгуулсан байна.	Жуулчдын гол чиглэл дагуу бүс нутгийн онцлогт тулгуурлан Хархорин суманд 07 сарын 15-17-ны хооронд “Торгоны зам-Хархорум хот” соёл, аялал жуулчлалын фестивалийг, Хужирт суманд 07 сарын 22-нд “Монгол эсгий урлалын баяр”, Бат-Өлзий суманд 7 сарын 23-нд “Сарлагийн баяр” эвентүүдийг зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 5.0 гаруй жуулчид үзэж сонирхсон. Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, улирлын хамаарлыг бууруулах зорилгоор Арвайхээр суманд 2023 оны 12 сарын 01-нд Улсын бүсийн “Тэмээчдийн баяр”, 12 сарын 9,10-нд Бат-Өлзий сумын Улаанцутгаланд “KARAKORUM ICE FESTIVAL” мөсөнд авиралтын тэмцээнийг тус тус зохион байгуулсан. Дээрх эвентүүдийг зохион байгуулахад орон нутгийн төсвөөс 80.0 сая, улсын төсвөөс 20.0 сая төгрөгийг зарцуулж, давхардсан тоогоор 8000 мянга гаруй жуулчид үзэж сонирхсон.	100
1.6.5	“Ай Ти Эм” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох;		Үзэсгэлэнд оролцогч аж ахуй нэгж, байгууллагын тоо	2022 онд 22 аж ахуй нэгж, байгууллага оролцсон.	Үзэсгэлэнд 25-аас доошгүй аж ахуй нэгж, байгууллагуудыг оролцуулсан байна.	-Жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг ITM-2023 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн 2023 оны 10 сарын 27-30-ны өдрүүдэд “Ногоон хөрөнгө оруулалт-бидний ирээдүй” уриатайгаар зохион байгуулагдаж тус аймгаас 20 жуулчны бааз, 4 зочид буудал, 2 үйлчилгээний цогцолбор төв, үзвэр үйлчилгээ эрхлэгч 1, нийт 27 аж ахуй нэгж, байгууллага нэгдсэн зохион байгуулалттайгаар оролцож үйл	100

						ажиллагаагаа сурталчилж, гэрээ хэлэлцээр байгууллаа.	
1.6.6	Uvurkhangaitravel гар утасны аппликейшны хөгжүүлэлтийг хийж, цахим сурталчилгааг эрчимжүүлэх.	-	Аппликейшн хэрэглэгчдийн тоо	2022 онд 632 иргэн ашигласан.	3000-аас доошгүй хэрэглэгчтэй болсон байх.	Аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах Uvurkhangaitravel гар утасны аппликейшны хөгжүүлэлтийг хийж, байгууллагын пэйж хуудас болон вэйб сайтаар дамжуулан иргэдэд хүргэж, хэрэглэгчдийн тоог 800-д хүргэсэн.	70
Зорилт 1.7 Уялдаа: АЗДҮАМХ 2.3.3.1, 2.3.3.2		Газар, газрын хэвлий түүний баялгийг хамгаалах зүй зохистой ашиглах, уул уурхайн нөхөн сэргээлтийн ажлыг зохион байгуулах, нийгмийн хариуцлагын гэрээг хэрэгжүүлж ажиллах					
1.7.1	Газар, газрын хэвлий түүний баялгийг хамгаалах зүй зохистой ашиглах, уул уурхайн нөхөн сэргээлтийн талаар УИХ, Засгийн газар, аймгийн Засаг даргаас дэвшүүлсэн бодлого, хөтөлбөр, шийдвэрийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	-	Хамтарсан хяналт шалгалт тоо, арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал	3 удаа хамтарсан хяналт шалгалт хийгдсэн.	Хамтарсан хяналт шалгалтыг 3-аас доошгүй удаа зохион байгуулж, хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллана.	-Уул уурхайн нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээний хэрэгжилтийг орон нутагт хангах ажлын хэсэг 5 удаа уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хамтарсан хяналт шалгалт хийж, нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх үүрэг чиглэл өгч ажилласан.	100
1.7.2	Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдтэй хамтран биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд эвдэлд орж нөхөн	-	Эвдрэлд орж нөхөн сэргээгдээгүй орхигдсон 60-аас доошгүй га талбайд нөхөн сэргээлтийн ажлыг стандартын дагуу хийлгэх	Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд нөхөн сэргээлт хийх ажил хийгдээгүй.	Дүйцүүлэн хамгаалах ажлыг хэрэгжүүлэн эвдрэлд орсон газарт нөхөн сэргээлтийн ажлыг хийлгэн хүлээн авч, акт гарган ажилласан байна.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Нарийнтээл, Баруунбаян-Улаан сумдын хилийн зааг Таацын голд гар аргаар ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж, нөхөн сэргээгдээгүй орхигдсон 30 га газарт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшин үйл ажиллагаа явуулж буй “АУМ-Алт”ХХК, “Өгөөмөр-Өргөө”ХХК, “Баярсгоулд” ХХК-иуд, Зүүнбаян-Улаан сумын Улаандэл хэмээх газарт хууль бус үйл ажиллагаа ажиллагааны улмаас эвдрэлд орсон 20 га газарт “Галт үнэг” ХХК, “Эм эс бэл	100

	сэргээгдээгүй орхигдсон газарт нөхөн сэргээлт хийлгүүлэх;					майнинг” ХХК-иуд тус тус техникийн нөхөн сэргээлт хийсэн. Мөн аймгийн ИТХ-ын 2019 оны 10/01 дугаар тогтоолоор бичил уурхайн зориулалтаар тусгай хэрэгцээнд авсан Нарийнтээл сумын орших 34.6 га газарт бичил уурхайн нөхөрлөлүүдээр техникийн нөхөн сэргээлгэж аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг актаар хүлээн авсан.	
1.7.3	Уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн нөхөн сэргээлтийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, БОМТөлөвлөгөөний биелэлтийг хүлээн авч, дүгнэлт гаргах;	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангуулан техникийн нөхөн сэргээлт 86-аас доошгүй га-д биологийн нөхөн сэргээлт 29-өөс доошгүй га талбайд нөхөн сэргээлт хийлгэн ажилласан байна.	2022 онд техникийн нөхөн сэргээлт 55.5 га, биологийн нөхөн сэргээлт 10.5 га талбайд нөхөн сэргээлт хийсэн	Нөхөн сэргээлтийг төлөвлөгөөний дагуу бүрэн хийлгүүлж хүлээн авсан байх	-Уул уурхайн нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээний хэрэгжилтийг орон нутагт хангах ажлын хэсэг 5 удаа уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хамтарсан хяналт шалгалт хийж, нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх үүрэг чиглэл өгч ажилласан. Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “АУМ-Алт”ХХК, “Өгөөмөр-Өргөө”ХХК, “Баярсгоулд” ХХК, “Империо майнинг” ХХК, “Галт үнэг” ХХК, “Эм эс бэл майнинг” ХХК-иуд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу техникийн нөхөн сэргээлт 85.07 га, биологийн нөхөн сэргээлт 31.5 га талбайд нөхөн сэргээлт хийсэн.	100
1.7.4	“Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах;	-	Төлөвлөгөө боловсруулж батлуулж, хэрэгжилтийг хангасан эсэх;	Төлөвлөгөө боловсруулан батлуулсан	Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан байна.	-Уул уурхайн нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээний хэрэгжилтийг орон нутагт хангах ажлын хэсэг 5 удаа уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хамтарсан хяналт шалгалт хийж, нөхөн сэргээлтийг ажлыг эрчимжүүлэх үүрэг чиглэл өгч ажилласан. Мөн ажлын хэсэг аймгийн хэмжээнд эвдэрсэн газрын	100

						тооллого судалгааг 07 дугаар сард хийж, www.eic.mn эвдэрсэн газрын мэдээллийн санд оруулан ажилласан. -2023 онд аймгийн хэмжээнд техникийн нөхөн сэргээлтийг 169.67 га, биологийн нөхөн сэргээлтийг 31.5 га талбайд хийж гүйцэтгэснийг аймгийн Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/245 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг хүлээн авч, акт, дүгнэлт гаргасан.	
1.7.8	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төслүүдэд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийж, байгаль орчны ерөнхий үнэлгээ дүгнэлт гарган, хэрэгжилтийг хангуулан ажиллах;	-	Гаргасан үнэлгээ, дүгнэлт, зөвшөөрлийг хууль тогтоомжийн хүрээнд гаргасан байх	2022 онд 30 иргэн, аж ахуйн нэгжийн төслийн үйл ажиллагаанд үйл байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийж дүгнэлт гаргасан.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулах хүсэлтийг “E-MONGOLIA” цахим системээр дамжуулан хүлээн авч, холбогдох дүгнэлтийг гарган цахимаар хүргүүлэн хуулийн хэрэгжилтийн хангах	-Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, шат дамжлагыг бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх хүрээнд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргах үйлчилгээг цахимжуулж, "e-mongolia" системд шилжүүлж, 2023 оны 12 сарын 01-ны байдлаар 15 иргэн, аж ахуйн нэгжид байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргаж цахимаар хүргүүлсэн.	100
1.7.9	Аймгийн нутаг дэвсгэрийн зарим хэсгийг тусгай хамгаалалтад авах үндэслэл боловсруулж, аймгийн Засаг даргын зөвлөл, ИТХурлаар хэлэлцүүлэх;	-	Аймгийн нутаг дэвсгэрийн зарим хэсгийг тусгай хамгаалалтад авах асуудлыг аймгийн ИТХурлаар хэлэлцүүлсэн байна.	Газар нутгийг тусгай хамгаалалтад саналыг Уянга, Нарийнтээл, Баруунбаян-Улаан, Богд сумдаас авсан.	Аймгийн ИТХурлаар газар нутгийг тусгай хамгаалалтад авах асуудлыг хэлэлцүүлсэн байна.	-Аймгийн газар нутгийн байгалийн унаган төрх, хэв шинжийг хадгалах, ховор, ховордсон ургамал, амьтан, усны нөөц, газрын өвөрмөц тогтоц, түүхийн дурсгалт газар түүний орчныг хамгаалах зорилгоор Онги, Таац голын урсац бүрэлдэх эх бүхий Уянга, Нарийнтээл сумдын нутаг орших “Хангайн нуруу”-ны салбар уулсын үзүүр төгсгөл хэсэг, Баруунбаян-Улаан, Богд сумдын нутагт орших “Зүүн богд уул”-ын нийт 154.170 га тус тус байгалийн нөөц газрын ангиллаар Улсын тусгай хамгаалалтад авах тухай аймгийн Засаг даргын саналыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 04	100

						дүгээр сарын 14-ны өдрийн 18/03 дугаар тогтоолоор дэмжсэн. Тус тусгай хамгаалалтад авах санал уламжлах тухай тогтоолыг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлээд байна. Тус яам одоогоор тусгай хамгаалалтад авах судалгааны ажил хийж байна.		
1.8 Байгаль орчин, уул уурхайн чиглэлээр хяналт, шалгалтын ажил зохион байгуулах;								
1.8.1	Шатахуун түгээх станцын үйл ажиллагаа эрхэлдэг 7 объектод хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах;	-	Хяналтын хуудсаар үнэлгээ өгч, илэрсэн зөрчил дутагдалд үндэслэн хяналт шалгалтын баримт бичиг үйлдэн, зөрчил дутагдлыг арилгуулсан байна.	2022 оны эрсдэлийн үнэлгээгээр эрсдэлтэй үнэлэгдсэн.	оны их	Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, 2023 онд эрсдэлийг бууруулж ажилласан байна.	Шатахуун түгээх станцын үйл ажиллагаа эрхэлдэг Хайрхандулаан сумын “Шинэ эзэмшил” ХХК, “Эх нутгийн буян” ХХК, Арвайхээр сумын “Арвайн сод ундарга” ХХК, “Мон суль” ХХК, “Арвайн тос” ХХК, Өлзийт сумын “Гүн зэгэстэй” ХХК, Хархорин сумын “МЭШ” ХХК-ийн нийт 7 ШТС-д хяналт шалгалт хийж, 01.1.4 дугаартай “үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах” хяналтын хуудсаар үнэлэхэд 18 хувьтай бага, 45.0-62.5 хувьтай буюу дундаас их эрсдэлтэй, хууль сахин мөрдөлт 43.7-79.0 хувьтай үнэлэгдлээ. Эрсдэлийн хувь багаар үнэлэгдсэн “Мон суль” ХХК-д цаашид анхаарах асуудлыг талаар заавар зөвлөгөө өгч, дундаас их эрсдэлтэй үнэлэгдсэн 6 ШТС-д илэрсэн дутагдлыг арилгуулахаар албан шаардлага хүргүүллээ. Албан шаардлагад ШТС-аас байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, менежментийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, нефть бүтээгдэхүүнийг тээвэрлэх, худалдан борлуулах, хадгалах явцад гарсан хог хаягдлыг бүртгэж, нөөцийн савны металл хийцийн оношлогоог тогтоосон хугацаанд хийлгэх үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангууллаа.	100

1.8.2	Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч 8 аж ахуйн нэгжид төлөвлөгөөт шалгалт хийж, хүрээлэн буй орчин бохирдуулж байгаа эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах;	-	Хяналтын хуудсаар үнэлгээ өгч, илэрсэн зөрчил дутагдалд үндэслэн хяналт шалгалтын баримт бичиг үйлдэн, зөрчил дутагдлыг арилгуулсан байна.	2022 оны эрсдлийн үнэлгээгээр эрсдэлтэй үнэлэгдсэн.	Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, 2023 онд эрсдлийг бууруулж ажилласан байна.	Төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд Хархорин сумын 5 жуулчны бааз, Нарийнтээл, Бүрд, Тарагт сумдын 36 цайны газар хамрагдав. Бат-Өлзий сумын 5 жуулчны баазын үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар 01.1.4 дугаартай хяналтын хуудасны үнэлгээ 39-43 хувьтай дунд эрсдэлтэй үнэлэгдэв. Улсын чанартай авто зам дагуух 36 цайны газар, жуулчны 5 баазад илэрсэн дутагдлыг арилгуулахаар байгаль орчны менежментийн төлөвлөгөө жил бүр боловсруулан, батлуулж, хэрэгжилтийг хангаж, биелэлтийг холбогдох газарт хүргүүлж байх, мөн ус ашиглалт, хог хаягдал, эко ариун цэврийн байгууламж барьж байгуулах, нүхэн жорлон татан буулгах зэрэг асуудлуудыг багтаасан албан шаардлага хүргүүлэв. Илэрсэн дутагдлыг арилгуулахаар өгсөн 7 албан шаардлагын хэрэгжилт 85 хувьтай байна. Урьдчилан сэргийлэх шалгалтын хүрээнд 24 нүхэн жорлонг буулгуулж, 1 амралтын газарт 500.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ ногдуулав. Ингэснээр тухайн үйлчилгээний улмаас хүрээлэн буй орчинд бохирдол үүсгэх эрсдэлийг бууруулах, эрсдэлээс сэргийлэх боломжтой боллоо.	100
1.8.3	10 сумын ШТС-ын шатахууны нөөцийн сав цэвэрлэгээ, металл хийцийн оношилогоо,	-	Шатахуун түгээх станцаас хүрээлэн буй орчинд үүсгэх бохирдлыг бууруулах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажил	2022 онд 8 сумын 48 ШТС-д хийсэн хяналтаар шатахууны нөөцийн савны цэвэрлэгээ хийгээгүй 25 ШТС байгаа нь 51.0 хувийг, савны ханын зузааны	2023 онд 10 сумын 25 ШТС-ийг хамруулсанаар аймгийн хэмжээний шатахуун түгээх станцуудаас хөрс, гүний ус бохирдуулах болзошгүй эрсдлийг бууруулах ажил зохион байгуулах	Өвөрхангай аймгийн хэмжээнд 19 сумын 82 ШТС үйл ажиллагаа явуулж байна. Энэ судалгаанд тус аймгийн төв болон 11 сумын нийт 62 ШТС-ын 161 нөөцийн савыг хамруулан газар дээр нь шалгалт хийж, бусад 7 сумын 20 ШТС-ийн үйл ажиллагааг үнэлэхдээ сумын байгаль орчны байцаагчаас судалгаа авсан. Уг судалгааг үндэслэн дүгнэж үзэхэд 265 эдгээр 265 шатахуун хадгалах нөөцийн	100

	<p>нөөцийн саванд хадгалагдаж байгаа шатахуун механик болон гадны хольц илрэх эсэхэд хяналт шалгалт хийх.</p>		<p>зохион байгуулах</p>	<p>хэмжилт хийлгэж, ашиглалтын хугацааг тогтоолгоогүй 32 ШТС байгаа нь 65.3 хувийг, нөөцийн саванд усны хольц байгаа эсэхийг хянахад 23 буюу 46.9 хувьд ус илэрсэн.</p>	<p>талаар аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд асуудал оруулан хэлэлцүүлэх</p>	<p>савны 90 хувийг Орос улсад үйлдвэрлэсэн хуучин сав байгаа эзэлж байна. Шатахууны нөөцийн савны цэвэрлэгээг 116 саванд хийгээгүй нь 72 хувийг, савны ханын зузааны хэмжилт хийлгэж, ашиглалтын хугацааг тогтоолгоогүй 110 сав байгаа нь 69.0 хувийг эзэлж байна. Дээрх ажлын хүрээнд нөөцийн саванд усны хольц байгаа эсэхийг газар дээр нь хянахад 35 саванд илэрсэн нь 21.7 хувийг эзэлж байна. Иймээс гүний ус, хөрс бохирдохоос сэргийлэхийн тулд далд суурилагдсан саванд металл хийцийн оношлогоог тогтоосон хугацаанд хийлгэх ажлыг 2024 оноос зохион байгуулах шаардлага үүссэнийг судалгаагаар нотоллоо.</p>	
1.8.4	<p>Хууль бус ан агнуур, мах түүхий эдийн худалдаалалт, тээвэрлэлт, мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх цаг үеийн шинж чанартай хамтарсан хяналт шалгалтуудыг зохион байгуулж үр дүнг тооцох, иргэд олон нийтэд мэдээлэх;</p>	-	<p>Мэдээлэл хүргэсэн иргэн, илрүүлсэн зөрчил, авсан арга хэмжээний тоо</p>	<p>2022 онд хууль бус ан агнуур, мах түүхий эдийн худалдаалалт, тээвэрлэсэн зөрчил 22 бүртгэгдсэн</p>	<p>Гэмт хэрэг, зөрчлийг өмнөх оноос бууруулсан байна.</p>	<p>Ойн тухай хууль зөрчсөн 23 иргэнд нийт 6.850.000 мянган төгрөгийн торгууль оногдуулж, ойд учирсан хохирлын 1.826.979 мянган төгрөгийг нөхөн төлүүлж, хууль бусаар бэлтгэсэн 149 ширхэг гуалин мод, 202.95 кг хуш модны самрыг хураан зохих журмын дагуу шийдвэрлэлээ. Гэмт хэргийн шинжтэй 2 гомдол мэдээллийг харьяаллын дагуу цагдаагийн байгууллагаар шалгуулах саналтайгаар Прокурорт хүргүүллээ. Амьтны тухай хууль зөрчсөн 33 иргэнд нийт 7.350.000 мянган төгрөгийн торгууль оногдуулж, байгаль орчинд учирсан хохирлын 102.894.000 мянган төгрөгийг нөхөн төлүүлж, цагаан зээр, тарваганы мах, махан ороомог, зэрлэг гахай, чоно, үнэгний арьс, эвэр яс, тагтаа, ногтруу, шонхор гэх мэт нийт 364 ширхэг амьтны гаралтай мах түүхий эд, эд зүйлсийг</p>	100

						<p>хураан зохих журмындагуу шийдвэрлэлээ.</p> <p>Цаг үеийн шинж чанартай хамтарсан эргүүлийг Хайрхандулаан, Тарагт, Нарийнтээл, Уянга, Зүүнбаян-Улаан, Арвайхээр гэх мэт сумдад 7, 8, 9 саруудад 5 удаа хийсэн.</p> <p>Аймгийн Засаг даргын хууль бус ан агнуур, тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай захирамжийг холбогдох төрийн байгууллага, албан тушаалтанд хүргүүлж ажиллалаа.</p> <p>-Сум бүрийн байгалийн онцлог, цаг үеийн байдалд тохируулан сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч нарыг 2023 онд урьдчилан сэргийлэх эргүүл, хяналт шалгалт хийх дэлгэрэнгүй хуваарийг гарган баталж хүргүүлж хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилласан. Үүний үр дүнд хууль бусаар ан агнах гэмт хэрэг зөрчлийн илрүүлэлт өмнөх оноос 50 орчим хувиар өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>Аймгийн Цагдаагийн газрын экологийн Цагдаагийн албан хаагчидтай хамтран Нарийнтээл, Онги, Хархорин сумын хяналтын постуудад хяналт шалгалтыг тогтмол хийж баруун аймгуудаас Улаанбаатар хотруу хууль бусаар агнасан амьтны гаралтай мах түүхий эдийн худалдаалалт тээвэрлэлтийг илрүүлэн таслан зогсоож ажиллаж байна. Нийт зөрчлийн тоо өмнөх оноос 20 хувиар буурлаа.</p>	
1.8.5	Хууль бусаар ашигт малтмал, байгалийн өнгөт чулуу олборлох эрэх хайх зөрчил гэмт хэргээс урьдчилан	-	Мэдээлэл хүргэсэн иргэн, илрүүлсэн зөрчил, авсан	2022 онд ойн зөрчил 27 бүртгэгдсэн.	Гэмт хэрэг, зөрчлийг өмнөх оноос бууруулсан байна.	Хууль бусаар ашигт малтмал эрэх, хайх, олборлох эрсдэлээс урьдчилан сэргийлэх хамтарсан шалгалтыг 11 удаа зохион байгуулж, зөвшөөрөлгүй ус ашигласан 1 аж ахуй нэгжид 5.0 сая төгрөгийн	100

	сэргийлэх цаг үеийн шинж чанартай хамтарсан хяналт шалгалтуудыг зохион байгуулж үр дүнг тооцох, иргэд олон нийтэд мэдээлэх;		арга хэмжээний тоо			торгууль, голын голдирол өөрчилсөн нэг аж ахуйн нэгж байгууллагад 20 сая төгрөгийн торгууль, бичил уурхай эрхлэх журам зөрчсөн 8 иргэн тус бүрд 1.5 сая төгрөгийн торгууль, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй 3 аж ахуйн нэгж бүрд тус бүр 10 сая төгрөгийн торгууль оногдуулж шийдвэрлэсэн. Нийт 6 байгууллага 8 иргэнд 70 сая төгрөгийн торгуулийг улсын байцаагч нараас оногдуулж ажиллалаа.	
1.8.6	Хог хаягдал орчны бохирдлыг бууруулах, иргэд, байгууллага, албан тушаалтны Хог хаягдлын тухай хуулиар хүлээсэн эрх үүргийн хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, иргэд олон нийтэд мэдээлэх;	-	Мэдээлэл хүргэсэн иргэн, илрүүлсэн зөрчил, авсан арга хэмжээний тоо	Орчны бохирдол хог хаягдлын чиглэлээр илэрсэн зөрчлийг арилгуулахаар 2 иргэн, 1 байгууллагад торгуулийн арга хэмжээ авч, 25 албан шаардлага хүргүүлсэн.	Зөрчлийн илрүүлэлтийн өмнөх оноос нэмэгдүүлсэн байна.	БОАЖ-ын Сайдын 2023 оны 02, 05 дугаар албан даалгаврын дагуу улсын чанартай авто зам дагуух Бүрд, Есөнзүйл, Өлзийт, Зүүнбаян-Улаан, Тарагт, Хайрхандулаан, Нарийнтээл, Арвайхээр сумдын нутгаар Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтэд шалгалт хийж 5 сумын Засаг даргад зөрчлийг арилгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлж хэрэгжилтийг хангуулж ажилласан. Тус хяналт шалгалтаар 14 хогийн цэгийг цэвэрлүүлэх, шаардлага хангахгүй 16 нүхэн жорлонг буулгуулахаар холбогдох иргэн, байгууллага, албан тушаалтанд улсын байцаагчийн албан шаардлага, зөвлөмж хүргүүлж хуульд заасан бусад арга хэмжээг авч ажилласан. -Дулаан үйлдвэрлэгч аж ахуй нэгж байгууллагуудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар ажиллаж холбогдох албан шаардлага өгч, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, үнсний хог хаягдлыг сар тутам зайлуулж байх үүрэг өгч ажилласан. -Сум, баг хорооны Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч нарт хог хаягдлын хуулиар хүлээсэн эрх, үүргийн талаар брошур, постер бэлтгэн цахим	100

						орчинд тавьж сурталчилсан. “Сумдын төрийн албан хаагч, иргэдэд хүрээлэн буй орчны гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хог хаягдлын талаарх ойлголт сэдэвт” сургалтыг Арвайхээр, Хайрхандулаан сумдад зохион байгууллаа.		
1.8.7	Дулааны эрчим хүч үйлдвэрлэгч аж ахуй нэгжийн үйл ажиллагаа эрхэлдэг 10 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах;	-	Хяналтын хуудсаар үнэлгээ өгч, илэрсэн зөрчил дутагдалд үндэслэн хяналт шалгалтын баримт бичиг үйлдэн, зөрчил дутагдлыг арилгуулсан байна.	2022 оны эрсдэлийн үнэлгээгээр эрсдэлтэй үнэлэгдсэн.	их	Дулаан үйлдвэрлэгч аж ахуй нэгжид хяналт тавьж ажилласан байна.	БОАЖЯамны салбарын улсын ерөнхий байцаагчийн 2023 оны 04 дүгээр сарын 06-ний өдөр баталсан удирдамжийн дагуу Арвайхээр сумын усан халаалтын 4,2 МВт хүртэл хүчин чадалтай 10 зуухны яндангийн утаанд агуулагдах агаар бохирдуулагч бодис стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд РТМ-600 gas analyser багажаар хэмжилт хийж, дулаан үйлдвэрлэгч аж ахуйн нэгжийн захирал нарт албан шаардлага өгч, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллалаа. -Төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд дулаан үйлдвэрлэгч 10 зууханд хяналт шалгалт хийлээ. Эдгээр 10 зуухны утааны найрлага нь агаар бохирдуулах бодисуудын зөвшөөрөгдөх дээд хэмжээнд 3 удаагийн хэмжилтийн дундаж утгаар авч үзэхэд MNS 5043:2016 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнд байна. Зуухны үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг тогтоох үйл ажиллагаанд 01.1.6 код бүхий “Дулааны цахилгаан сатнц, уурын болон усан халаалтын зуух ашиглалатаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудас”-аар үнэлэхэд “Газрын улаач” ХХК-ний зуух, “Дэлгэрэх хүнс” ХХК-ний зуух, “Хангамж өргөө” ХХК-ний зуух, “Мөнхбосго” ХХК-ний зуух, ЗХ-ний 256 ангийн зуухнууд,	100

						“Дунд” эрсдэлтэй, “Арвай-илч ХХК-ний зуух, Өв илч ХХК-ний, Өв пост ХХК-ний зуухнууд “Их” эрсдэлтэй тус тус үнэлэгдсэн. Шалгалтад хамрагдсан дээрх аж ахуй нэгжүүдэд илэрсэн дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлж, үүрэг даалгавар өгч, биелэлтэд хяналт тавьж ажилласан.		
1.8.10	Авто засварын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагаанд хяналт тавьж орчны аюултай хог хаягдлын цуглуулалт, хадгалалт хамгаалалтын байдалд тандалт судалгаа хийх;	-	Хяналтын хуудсаар үнэлгээ өгч, илэрсэн зөрчил дутагдалд үндэслэн хяналт шалгалтын баримт бичиг үйлдэн, зөрчил дутагдлыг арилгуулсан байна.	2022 оны эрсдлийн үнэлгээгээр эрсдэлтэй үнэлэгдсэн	их	Авто засварын үйл ажиллагаанаас үүдэлтэй орчны бохирдлыг бууруулах арга хэмжээ авсан байна.	“Авто засварын үйлчилгээ явуулж буй газруудаас гарч байгаа тос, тосолгооны материал, түүний сав суулга, маслын шүүр, аккумулятор, hybrid авто машины хуурай зай хураагуур гэх мэт аюултай хог хаягдлын цуглуулалт, хадгалалт хамгаалалт, устгал, тээвэрлэлтийн байдалд 2023 оны 06 дугаар сарын 15-16-ний өдрүүдэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийн, ажилаллаа. Хяналт шалгалтаар хоёрдогч түүхий эд)аккумулятор(хүлээн авдаг 6 иргэн, Авто засвар, тос тосолгоо хийдэг 12 аж ахуй нэгж, хамрагдаж хаягдал тосоо хэрхэн хаана зайлуулдаг, хаягдал аккумулятор хадгалалтын байдалд мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч, техникийн ашгиласан тос, хаягдал аккумуляторыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажилланаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж холбогдох баримт бичиг, бусад мэдээллийн нэгтгэн тайлан мэдээг хугацаанд хүргэн ажилласан.	100
1.8.11	Арьс шир, ноос, мах боловсруулах үйлдвэрүүдээс гаралтай орчны бохирдлын байдалд хяналт шалгалт хийх;	-	Хяналтын хуудсаар үнэлгээ өгч, илэрсэн зөрчил дутагдалд үндэслэн хяналт	2022 оны эрсдлийн үнэлгээгээр эрсдэлтэй үнэлэгдсэн	их	Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж ажилласан байна.	2023 оны шинжилгээт хяналт шалгалтын хүрээнд “Онги ус суваг” ОНӨААТҮГ-ын харьяа Арвайхээр сумын цэвэрлэх байгууламж, “Ноос ирээдүй” ХХК, “Арьс ирээдүй” ХХК, үйлдвэрүүдээс гарч байгаа бохир уснаас дээж авч Ус цаг уур орчны	100

			шалгалтын баримт бичиг үйлдэн, зөрчил дутагдлыг арилгуулсан байна.			шинжилгээний төвийн магадлан итгэмжлэгдсэн лабораторид хүргэсэн. Арвайхээр сумын цэвэрлэх байгууламж, Ноос ирээдүй ХХК-ны дээжийн хариу үзүүлэлт нь Усны чанар, Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэрлэгдсэн бохир ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015 стандартын шаардлага хагнасан бол "Арьс ирээдүй" ХХК-ний дээжийн хариу стандарт хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлттэй гарсан зөрчилд зөрчлийн хэрэг нээн байгаль орчинд учруулсан нөхөн төлбөрийг тогтоолгож, торгуулийн арга хэмжээ авч, албан шаардлага өгч ажилласан.	
1.8.12	Хүрээлэн буй орчныг хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт сурталчилгаа нөлөөллийн ажлыг зохион байгуулах;	ГХУСАЗ СЗ 3.3 сая	Мэдээлэл хүргэсэн иргэн, илрүүлсэн зөрчил, авсан арга хэмжээний тоо	2023 онд урьдчилан сэргийлэх чиглэлээр 9.3 сая төгрөг зарцуулж, зөрчлийг өмнөх оноос 37 хувиар бууруулсан.	Хүрээлэн буй орчныг хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлийг өмнөх оноос бууруулсан байна.	-Аймгийн ГХУСАЗСЗ-тэй хамтран байгаль орчныг хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх 10 ширхэг контент хийж цахим хэлбэрээр түгээж ажиллаж байна. -Ан амьтны экологи эдийн засгийн үнэлгээг иргэдэд сурталчлах зорилгоор 2 төрлийн самбар, хулдаасан хэвлэлийг 10 суманд хүргүүлсэн. -Гучин-Ус, Хайрхандулаан, Төгрөг, Баруунбаян-Улаан, Богд Нарийнтээл, Бат-Өлзий, Хужирт, Хархорин, Уянга, Зүүнбаян-Улаан сумдын ЗДТГ-ын албан хаагчдад байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт хийсэн. Хархорин, Арвайхээр сумдад Эко клубүүдын чуулга уулзалтыг зохион байгуулсан.	100
ХОЁР. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ							
Зорилт 2.1		Байгууллагын дотоод хяналт, архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг хэрэгжүүлэх					
2.1.1	Байгууллагын үйл ажиллагаанд дотоод	-	Дотоод хяналтын	2 удаа зохион байгуулсан		Байгууллагын бүтцэд өөрчлөлт орсонтой холбогдуулан Дотоод хяналтын нэгжийн	

	<p>хяналт зохион байгуулах;</p>		<p>чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ, чанар, үр дүн</p>		<p>Дотоод хяналтын нэгжийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлсэн байна.</p>	<p>бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж, газрын даргын 2023 оны 03 сарын 31-ний өдрийн А/06 дугаар тушаалаар батлуулсан. Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг газрын даргаар батлуулж, ажлын хэсэг 2023 оны 4 сард тус харъяа Сум дундын Ойн анги, Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (улсын байцаагч), байгаль хамгаалагч нарын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, сумдын удирдлагуудад ЗГ-ын 2022 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ыг танилцуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах талаар талаар зөвлөгөө, мэдээлэл өглөө. Мөн ой цэвэрлэгээний журмаар хийгдэж байгаа мод бэлтгэлийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийж, зарим илэрсэн дутагдлуудыг газар дээр нь арилгуулж, цаашид давтахгүй байх талаар ойн мэргэжлийн байгууллагууд, хяналт тавин ажиллаж байгаа Сум дундын Ойн анги, Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нарт үүрэг чиглэл өгч ажиллалаа.</p> <p>-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Дотоод хяналтын баг газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2023 оны 12 сарын 06-14-ны өдрүүдэд Гучин-Ус, Төгрөг, Богд, Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Хайрхандулаан, Уянга, Зүүнбаян-Улаан, Хужирт, Бат-</p>	<p>100</p>
--	---------------------------------	--	---	--	--	--	------------

						Өлзий сумдад дотоод хяналт шалгалт зохион байгуулж, сумдын удирдлагууд болон холбогдох албан хаагчдад Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, ЗГ-ын 2022 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ыг танилцуулж, сумдад 2023 онд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдсэн ажил болон 2024 оны орлого арга хэмжээний төлөвлөлт, байгаль орчны төсөв мэдээллийн сангийн программын ашиглалтад хяналт үнэлгээ хийж, мэргэшил арга зүйгээр хангаж зөвлөн туслах ажил зохион байгууллаа.	
2.1.2	Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажилах;	-	-Авлига ашиг сонирхлын зөрчил гарсан эсэх	Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажилласнаар авлига ашиг сонирхлын зөрчил гаргасан албан хаагч байхгүй	-Авлигын эсрэг төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах -ХАСХОМ, ХАСУМ-ийг холбогдох албан хаагчдаас хуулийн хугацаанд гаргуулсан байх -Мэдээ тайлан, судалгааг тухай бүр гаргах	Байгууллагын 2023 оны авлигын эсрэг төлөвлөгөөг боловсруулж, газрын даргаар батлуулан вэйб сайтад байршуулж, хэрэгжилтийг ханган ажиллалаа. ХАСХОМ, ХАСУМ-ийг холбогдох албан хаагчдаар хуулийн хугацаанд гаргуулж, холбогдох судалгааг тухай бүр хугацаанд нь гаргаж байна. Авлигатай тэмцэх газраас гаргасан авлигын эсрэг видео бичлэг шторикийг байгууллагын вэйб сайт болон пэйж хуудсанд тухай бүр байршуулж иргэдэд түгээж байна. Авлигатай тэмцэх газар, аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсээс зохион байгуулсан цахим болон танхимын сургалтуудад холбогдох албан хаагчдыг тухай бүр хамруулж, сумдын БОХУБайцаагч, Байгаль хамгаалагч нарын нэгдсэн сургалтаар Авлига ашиг сонирхлын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар аймгийн Прокурор	100

						Дэлгэрмаагаар мэдээлэл хийлгэж, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилж ажилласан.	
2.1.3	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангах;	-	Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгээр	2022 оны төлөвлөгөө 96,7 хувьтай хэрэгжсэн.	Байгууллагын төлөвлөгөөг боловсруулж батлуулан хэрэгжилт үр дүнг тооцож ажилласан байх;	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг хангах хүрээнд албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг тооцон ажиллалаа.	100
2.1.4	Тухайн жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэж, түүний мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж биелэлтийг хангах;	-	Чанар, үр дүн, хэрэгжилтийн хувь, хугацаа	Тогтоосон хугацаанд тайлагнасан.	Хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журмын дагуу тайланг нэгтгэж биелэлт, үр дүнг тооцон холбогдох газарт тайлагнасан байх;	Хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журмын дагуу байгууллагын 2022 оны тайланг нэгтгэн гаргаж аймгийн ЗДТГ-ын ХШҮХэлтэст албан тоотой тогтоосон хугацаанд хүргүүлсэн. Хяналт шинжилгээ-үнэлгээний дүнгээр 89,0 хувьтай үнэлэгдэж түүний мөрөөр хэрэгжүүлэх зөвлөмжийн дагуу гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөг боловсруулж батлуулан ажиллаж байна.	100
2.1.5	Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;	-	Архив, албан хэргийг холбогдох хууль, журам, заавар, стандартын дагуу хөтөлсөн байна.	Архив албан хэрэг хөтлөлтийг заавар стандартын дагуу хөтлөн явуулсан.	-Албан хаагчдад сургалт зохион байгуулах -Заавар стандартыг мөрдөж ажиллах	“Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай” хууль, ЗГ-ын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, Стандарт хэмжил зүйн газрын даргын 2021 оны с/30 дугаар тушаалаар батлагдсан MNS 5140-2:2021 стандарт, ЗГ-ын 2021 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”-уудыг байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна. -Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг Архив-бичиг хэргийн ажилтантай хамтран боловсруулж газрын даргаар батлууллаа.	100

ГУРАВ.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ

Зорилт 3.1		Байгууллагаас үзүүлж буй төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгжид холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ил тод, чирэгдэлгүй, түргэн шуурхай, хүртээмжтэй болгох					
3.1.1	Иргэдээс ирсэн өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авч шуурхай шийдвэрлэх;	-	Ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, мэдээ тайланг холбогдох байгууллагад тайлагнасан байдал	2022 онд газрын хэмжээнд 37 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирж хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.	-Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг бүртгэж эзэнжүүлэн шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллах -Өргөдөл гомдлын мэдээг холбогдох дээд байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлсэн байх	2023 оны жилийн эцсийн байдлаар газрын хэмжээнд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 32 өргөдөл, гомдол ирснийг хүлээн авч бүртгэн холбогдох албан тушаалтанд газрын даргын цохолтоор хүлээлгэн өгч, хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. Өргөдөл гомдлын мэдээг холбогдох байгууллагад улирал бүр гарган тайлагнаж, байгууллагын цахим сайтад өргөдөл гомдлын талаарх мэдээ мэдээллийг байршуулж ил тод байдлыг ханган ажиллаж байна.	100
3.1.2	Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ ус, рашаан ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, ой, ан амьтны экологи эдийн засгийн үнэлгээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гаргах.	-	Гаргасан үнэлгээ, дүгнэлт, зөвшөөрлийг хууль тогтоомжийн хүрээнд гаргасан байх	5 төрлийн үйлчилгээг цахимжуулж, "E-MONGOLIA" СИСТЕМД-д шилжүүлсэн.	Иргэдэд үзүүлж буй үйлчилгээг хууль тогтоомжийн хүрээнд чирэгдэлгүй, хурдан шуурхай хүргэсэн байх.	-Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, шат дамжлагыг бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх хүрээнд ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гүн өрмийн худаг гаргах зөвшөөрөл, усны мэргэжлийн байгууллагын эрх олгох дүгнэлт, аймгийн Засаг даргын тодорхойлолт зэрэг 5 төрлийн үйлчилгээг цахимжуулж, "E-MONGOLIA" СИСТЕМД-д шилжүүлсэн. 2023 онд уг үйлчилгээг иргэдэд сурталчлах ажлыг байгууллагын вэйб сайт, пэйж хуудас, "Нээлттэй хаалганы өдөрлөг"-өөр сурталчилж ажиллалаа. 2023 оны жилийн эцсийн байдлаар ус ашиглуулах дүгнэлт 10, ус, рашаан ашиглуулах зөвшөөрөл 4, цооног өрөмдөж худаг гаргах зөвшөөрөл 13, байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт 15, ан амьтны экологи эдийн засгийн үнэлгээ 28, ойл учруулсан хохирлын үнэлгээ 11, мэргэжлийн байгууллагын дүгнэлт 2, хуш	100

						модны самрын ургац тогтоосон дүгнэлт 1-г тус тус гаргасан байна.		
	Дундаж үнэлгээ							97,7

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

ТӨЛӨВЛӨГӨӨ ТАЙЛАГНАСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

И.ДОРЖСҮРЭН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

Г.БАЯСГАЛАН